Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Эдийн засаг, хөгжлийн яам

2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | |
| 3.1. | Макро эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашиг, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, төлөвлөлтийг боловсруулна. | - | - | - | - | Макро эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашиг, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, төлөвлөлтийг боловсруулах хүрээнд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай макро | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийг боловсруулж, танилцуулга бэлтгэсэн. Мөн Монгол Улсын Засгийн газраас 2024 онд баримтлах бодлого тэргүүлэх чиглэлийг 1/ Эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, 2/ Экспортыг нэмэгдүүлэх, 3 /Зохицуулалтыг хялбарчилж, бизнесийг дэмжих, 4/ Салбаруудыг татааснаас чөлөөлж, цогц шинэчлэл хийх, 5/ Хөрөнгө оруулалтыг дэмжиж, эдийн засгийг төрөлжүүлэх, 6/ Амьдралын чанарыг дээшлүүлэх хүрээнд бодлогын чиглэл, арга хэмжээг тодорхойлсон. 2024 онд эдийн засаг 7.0 хувиар өсөхөөр төсөөлж байна. Уул уурхайн бүтээгдэхүүнүүд, нүүрсний олборлолт, Оюутолгойн гүний уурхайн олборлолт эрчимжиж, зэсийн баяжмал дахь | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | агууламж нэмэгдсэнээр уул уурхай, түүнээс хамааралтай тээврийн салбарын өсөлт эдийн засгийн өсөлтийн гуравны нэг орчмыг бүрдүүлнэ. Улсын инфляц 2023 оны 8 дугаар сард 10.0 хувьтай гарсан бол 2023 оны эцэст нэг оронтой тоонд хүрэх төлөвтэй байна. Харин 2024 онд Засгийн газар, төв банкнаас макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд төсөв, мөнгөний хатуу бодлогыг хэрэгжүүлж байна. Мөн экспортын орлогыг нэмэгдүүлж, валютын бодит мөнгөн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний үр дүнд гадаад валютын албан нөөц нэмэгдэж байна. 2023 онд экспорт 13.1 тэрбум ам.доллар, импорт 9.5 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдаа 3.6 тэрбум ам.долларын ашигтай гарах төлөвтэй байгаа ба | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2024 онд экспорт 15.4 тэрбум ам.доллар, импорт 10.0 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдаа 5.4 тэрбум ам.долларын ашигтай гарахаар төсөөлж байна. | |
| 3.1.1 | Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгаж, бодлого зохицуулалтаар хангана. | - | Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох. | Монгол Улсын Их Хурлын 2022 оны 23 дугаар тогтоол "Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө" батлагдсан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Монгол Улсын 2024 оны эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, танилцуулсан байна. /1 танилцуулга/ | Монгол Улсын 2024 оны эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, танилцуулгыг бэлдэж хүргүүлсэн. Засгийн газраас 2024 онд баримтлах бодлого, тэргүүлэх чиглэлд: 1/ Эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх: Эдийн засгийг тогтворжуулах хүрээнд 2022-2023 онуудад авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг хадгалж, 2024 онд макро тогтвортой орчныг дэмжсэн төсөв, мөнгөний бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, улсын зээлжих зэрэглэлийг нэг шатаар ахиулна. 2/ Экспортыг нэмэгдүүлэх: Эдийн засгийн суурийг тэлэх, төрөлжүүлэх хүрээнд уул уурхайн болон уул | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээг 2024 онд үргэлжлүүлэн авч хэрэгжүүлнэ 3 /Зохицуулалтыг хялбарчилж, бизнесийг дэмжих: Аливаа төрлийн бизнес эрхлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг шийдвэрлэх чиглэлд төрийн зохицуулалтыг хялбарчилж, хувийн секторын чөлөөт өрсөлдөөнийг дэмжих арга хэмжээг 2024 онд авч хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд бизнесийн бүх төрлийн үйл ажиллагаанд байгаль орчны үнэлгээ хийлгэхийг шаардаж буй зохицуулалтыг оновчтой болгож, хялбаршуулна. 4/ Салбаруудыг татаасаас чөлөөлж, цогц шинэчлэл хийх: Эдийн засгийн салбаруудын өрсөлдөөнийг дэмжих, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах чиглэлд 2024 онд хөдөө аж ахуйн салбарт бодлогын цогц шинэчлэл хийх, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, нийтийн тээврийн тогтолцоог шинэчлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. 5/ Хөрөнгө оруулалтыг дэмжиж, эдийн засгийг төрөлжүүлэх: Эдийн засгийг төрөлжүүлэх, бүтээгдэхүүнүүдийн боловсруулалтын түвшнийг шат шатаар ахиулах хүрээнд хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, уул уурхайн болон уул уурхайн бус салбарын үйлдвэрлэлийг дэмжинэ. 6/ Амьдралын чанарыг дээшлүүлэх: Боловсрол, эрүүл мэндийн салбарт шинэчлэл хийх, иргэдийн нийгмийн баталгааг сайжруулах чиглэлд 2024 онд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | |
| 3.1.2 | Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн | Үйл ажиллагааны зардлаар | Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо | Монгол Улсын Их Хурлын 2022 оны 23 дугаар тогтоол "Монгол Улсын хөгжлийн 2023 оны | Эхний хагас жилд: Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн дунд хугацааны тооцоо, төсөөллийн танилцуулгыг | Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөл, түүний танилцуулгыг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | танилцуулгыг гүйцэтгэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, УИХ-д өргөн мэдүүлнэ. | | | төлөвлөгөө" батлагдсан. | боловсруулсан байна. /1 удаа/ Жилийн эцэст: - | бэлдэж хүргүүлсэн. “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2023.04.28-нд УИХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд, 2023.05.30-ний өдөр УИХ нэгдсэн чуулганаар батлуулсан. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд: Нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн 2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр 52.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 21.4 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 28.4 их наяд төгрөг болж, өмнөх оноос 4.8 хувиар тус тус өссөн. Эдийн засгийн нийт эрэлт 2022 онд хүлээлтээс давж сэргэсэн байна. Өрхийн хэрэглээ 2022 онд 7.4 хувиар, үндсэн хөрөнгийн хуримтлал 15.5 хувиар өссөн нь нийт эрэлтийг дэмжсэн бол цэвэр экспорт 29.3 хувиар буурсан нь нийт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрэлтэд сөрөг нөлөө үзүүлсэн байна. Өрхийн хэрэглээ 2022 онд өссөн нь цар тахлын өмнөх 2019 оны түвшнээс 3.2 хувиар давсан байна. Өрхийн нийт хэрэглээ өсөж байгаа ч Үндэсний статистикийн хорооны тоон мэдээллээр 2022 онд бодит орлого 0.7 хувиар буурсан байна. Жилийн инфляц 2022 оны эцэст улсын хэмжээнд 13.2 хувь гарлаа. Инфляц 2022 оны 6 дугаар сард хамгийн оргилдоо буюу 16.1 хувьд хүрсэн бол сүүлийн хагас жилд аажмаар буурч байна. Гадаад зах зээлд хүнсний бүтээгдэхүүний үнэ буурсан, гадаад валютын албан нөөц өссөн зэргээс шалтгаалан оны сүүлийн саруудад инфляцын түвшин буурсан хэдий ч Монголбанкны зорилтот түвшнээс хоёр дахин өндөр хэвээр байна. Монгол улс 2022 онд 162 улстай худалдаа хийж, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гадаад худалдааны нийт бараа эргэлт 21.2 тэрбум ам.доллар болж, өмнөх оноос 32.1 хувиар өссөн бол гадаад худалдааны тэнцэл 3.2 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Экспорт өмнөх оны мөн үеэс 35.7 хувиар өсөж 12.5 тэрбум ам.долларт хүрэхэд нүүрсний экспорт 135.5 хувиар буюу 3.7 тэрбум ам.доллароор өссөн нь голлон нөлөөлөв. | |
| 3.1.3 | Монгол Улсын тухайн оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Тооцоо төсөөллийн танилцуулгын тоо | Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд танилцуулга, холбогдох тооцоо, төсөөлөл хийж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-аар батлуулсан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Макро эдийн засгийн нөхцөл байдал, 2024 оны тооцоо, төсөөлөл, тэргүүлэх чиглэлийн танилцуулгыг боловсруулсан байна. /1 удаа/ | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийг хийж, танилцуулга боловсруулж, Сангийн яаманд хүргүүлсэн. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг 2023.09.29-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлж, 2023.11.10-ны өдөр УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар батлуулсан. Эдийн засгийн өсөлт 2023 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оны жилийн эцэст 6.0 хувьд хүрэхээр төсөөлж байна. Уул уурхайн бүтээгдэхүүний гадаад эрэлт өндөр, экспорт тогтвортой нэмэгдэж, 2023 оны сүүлийн хагаст уул уурхайн салбар (нүүрс олборлолт, зэсийн баяжмалын үйлдвэрлэл) эдийн засгийн өсөлтийг голлон дэмжсэн хэвээр байна. 2024 онд эдийн засаг 7.0 хувиар өсөхөөр төсөөлж байна. Уул уурхайн бүтээгдэхүүнүүд, нүүрсний олборлолт, Оюутолгойн гүний уурхайн олборлолт эрчимжиж, зэсийн баяжмал дахь агууламж нэмэгдсэнээр уул уурхай, түүнээс хамааралтай тээврийн салбарын өсөлт эдийн засгийн өсөлтийн гуравны нэг орчмыг бүрдүүлнэ. Улсын инфляц 2023 оны 8 дугаар сард 10.0 хувьтай гарсан бол 2023 оны эцэст нэг оронтой тоонд хүрэх | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөвтэй байна. Харин 2024 онд Засгийн газар, төв банкнаас макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд төсөв, мөнгөний хатуу бодлогыг хэрэгжүүлж байна. Мөн экспортын орлогыг нэмэгдүүлж, валютын бодит мөнгөн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний үр дүнд гадаад валютын албан нөөц нэмэгдэж байна. 2023 онд экспорт 13.1 тэрбум ам.доллар, импорт 9.5 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдаа 3.6 тэрбум ам.долларын ашигтай гарах төлөвтэй байгаа ба 2024 онд экспорт 15.4 тэрбум ам.доллар, импорт 10.0 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдаа 5.4 тэрбум ам.долларын ашигтай гарахаар төсөөлж байна. | |
| 3.1.4 | Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг | Үйл ажиллагаан ы зардлаар | Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо | Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Макро эдийн засгийн нөхцөл | Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөл, танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ. | | | танилцуулга, холбогдох тооцоо, төсөөлөл хийж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-аар батлуулсан. | байдал, 2024-2026 оны тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулсан байна. /1 удаа/ | оны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөл хийж, танилцуулгыг боловсруулсан. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг 2023.04.28-нд УИХ-д өргөн мэдүүлж 2023.05.30-ны өдөр УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар батлуулсан. Макро эдийн засгийн танилцуулгыг 1/ Дэлхийн эдийн засгийн төлөв, 2/ Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн хандлага, 3/ Монгол Улсын эдийн засгийн 2022 оны урьдчилсан гүйцэтгэл, 4/ Эдийн засгийн 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, 5/ Макро эдийн засгийн 2024 оны хандлага, 2025-2026 оны төсөөлөл, бодлогын чиглэл гэсэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | агуулгын хүрээнд бэлтгэсэн. | |
| 3.2. | Макро эдийн засгийн судалгааг хийж, эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлно. | - | - | - | - | Монгол Улсын 2024 оны Улсын хөгжлийн төлөвлөгөө, 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, 2024 оны төсвийн тухай хуулийн танилцуулгад Засгийн газраас 2024 онд баримтлах бодлого, тэргүүлэх чиглэлийг тус тус нэгтгэж тодорхойлсон. Тухайлбал, эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, экспортыг нэмэгдүүлэх, зохицуулалтыг хялбарчлах, бизнесийг дэмжих, салбаруудын татааснаас чөлөөлж, цогц шинэчлэл хийх, хөрөнгө оруулалтыг дэмжиж, эдийн засгийг төрөлжүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэх зэрэг нийт 8 зорилтын хүрээнд холбогдох арга хэмжээний саналыг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.1 | Эдийн засгийн нөхцөл байдалд улирал (Macro diagnostics) тутам дүн шинжилгээ хийж, танилцуулга боловсруулж, танилцуулна. | Үйл ажиллагаан ы зардлаар | Дүн шинжилгээний тоо | Монгол Улсын 2022 оны эдийн засгийн нөхцөл байдал, жилийн эцсийн гүйцэтгэл хийж танилцуулсан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Дүн шинжилгээ хийж, танилцуулсан байна. /1 танилцуулга/ | Макро эдийн засгийн 2023 оны 1-3 дугаар улирлын статистик гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, танилцуулга боловсруулж, яамны цахим хуудсанд байршуулсан. Уг танилцуулгыг 1/Макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, хүлээгдэж буй гүйцэтгэл, 2/ Макро эдийн засгийн 2024 оны чиг хандлага, төсөөлөл, 3/ Засгийн газраас 2024 онд баримтлах бодлого, тэргүүлэх чиглэл, 4/ Болзошгүй эрсдэлийн тойм гэсэн сэдвийн хүрээнд боловсруулсан ба дараах холбоосоор орж танилцах боломжтой: http://med.gov.mn/print | 100% |
| 3.2.2 | Макро эдийн засгийн богино, дунд хугацааны загваруудыг хөгжүүлж, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөлд ашиглана. | Үйл ажиллагаан ы зардлаар | Хөгжүүлсэн загварын тоо | Мэдээллийн дата баазыг бүрдүүлж, туршилт тооцооллуудыг гүйцэтгэсэн. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Загвар хөгжүүлсэн байна. /1 загвар/ | Макро эдийн засгийн тоон үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийг Excel программд суурилсан загвар, хэрэгслийг шинэчлэн сайжруулан ажилласан. Мөн GAP загварт төсвийн бодлогын үзүүлэх | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нөлөөг тусгаж хөгжүүлж, тоон өгөгдлийг бэлтгэсэн. Mathlab программыг ашиглан сүүлийн улиралд GAP загварыг ашиглаж макро эдийн засгийн үзүүлэлтийн шинжилгээг хийсэн. | |
| 3.2.3 | Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх тухай Засгийн газрын 2022 оны 362-р тогтоолын хэрэгжилтийг хангуулж ажиллана. | Үйл ажиллагаааны зардлаар | ЗГ-ын хуралдаанд танилцуулсан тоо | Засгийн газрын 2022 оны 10 сард 362 дугаар тогтоол батлагдсан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Валютын орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр хийсэн ажил, асуудлыг дүгнэн тухай бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулах, бодлогын шийдвэр гаргуулсан байна. | "Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцыг нийт 12 удаа Засгийн хуралдаанд танилцуулж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг Засгийн газрын тэмдэглэлүүдэд тусгуулж холбогдох байгууллагад үүрэг болгож ажилласан. Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах хүрээнд валютын орлого төвлөрүүлэх, экспорт, тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, гааль, татварын автомат | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүрдүүлэлтийн систем бий болгох, хяналтыг сайжруулах, ашигт малтмалын олборлолт, боловсруулалт, тээвэрлэлтийн гэрээг ил тод болгох чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үр дүнд 2022 оны 8 дугаар сард 2.7 тэрбум ам.долларт хүрч буураад байсан гадаад валютын албан нөөц 2023 оны 10 дугаар сарын эцсийн байдлаар 4 тэрбум ам.долларт хүрч нэмэгдсэн. Гадаад валютын нөөц нэмэгдсэн нь эдийн засаг сэргэж, инфляцын түвшин буурч, гадаад валютын зах зээл тогтворжиход чухал хувь нэмэр оруулж байна. Үндэсний статистикийн хорооны тооцоогоор дотоодын нийт бүтээгдэхүүн 2023 оны эхний гурван улиралд 6.9 хувиар өслөө. Экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээний үр дүнд өмнөх оны мөн үед 20 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хувийн уналттай байсан уул уурхайн салбарын үйлдвэрлэл энэ оны эхний 9 сард 33хувиар өсөж, нийт эдийн засгийн өсөлтийг дэмжсэн байна. Гадаад валютын албан нөөц нэмэгдэж, валютын зах зээл тогтворжсоноор импортын бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт саарч, өмнөх онд 17 хувьд хүрч байсан инфляц 2023 оны 10 дугаар сарын эцэст 9 хувьд хүрч буурсан. Экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээний үр дүнд 2023 оны эхний 9 сарын байдлаар нүүрсний экспорт 46.8 сая тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 27.8 сая тонноор, зэсийн баяжмалын экспорт 1,152 мянган тоннд хүрч өнгөрсөн оны мөн үеэс 5 хувиар, төмрийн хүдрийн экспорт 4.2 сая тоннд хүрч өнгөрсөн оны мөн үеэс 33 хувиар, газрын тосны экспорт 3.2 сая баррельд хүрч өнгөрсөн оны мөн үеэс | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2 сая баррелиар тус тус өссөн. | |
| 3.2.4 | Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, голлох салбаруудын бүтээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай бодлогын шийдвэр гаргалтын саналыг боловсруулна. | Үйл ажиллагааны зардлаар | ЗГ-ын хуралдаанд танилцуулсан тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, голлох салбаруудын бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр судалж, тухай бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулах, бодлогын шийдвэр гаргуулсан байна. | Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 233 дугаар тогтоол 2023 оны 06 дугаар сарын 21-ны өдөр батлагдсан. Уг тогтоолын хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайдын 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/58 дугаар тушаалаар байгуулсан. Уг тогтоолын хэрэгжилтийг 2023 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж хэрэгжилтийг ханган ажилласан. Мөн Засгийн газрын хуралдааны 11 дүгээр сарын 1-ний өдрийн 44 дүгээр тэмдэглэл гарсан. | 100% |
| 3.2.5 | Засгийн газрын бусад байгууллагатай хамтран улсын эдийн засгийн | Үйл ажиллагааны зардлаар | Ажлын хэсэгт гүйцэтгэсэн тооцоолол, | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: | Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл боловсруулах | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | томоохон төслүүдийн ОУ-ын гэрээг байгуулах, хуулийн болон журмын төсөл боловсруулах ажлын хэсгүүдэд оролцож, хамтран ажиллана. | | судалгаа, танилцуулгын тоо | | Тухай бүр гүйцэтгэнэ. | ажлын хэсэгт суурь судалгаа, Хөгжлийн сангийн загвар, хуулийн төслийг Засгийн газар, Улсын Их Хурлын даргад танилцуулах танилцуулгыг бэлтгэж хамтран ажилласан. - Монгол Улсаас Оросын холбооны Улсад нийлүүлж буй бараа бүтээгдэхүүнд ногдуулж буй татварын хэмжээг бууруулах, худалдаан дахь техникийн саад тотгорыг багасгах зорилгоор Чөлөөт худалдааны түр хэлэлцээр байгуулах асуудлаарх ажлын хэсэгт ажиллаж байна. - Монгол Улсын Их Хурлын 19 дүгээр тогтоолын хэрэгжилт болон ноос ноолуурын боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэхтэйгээр холбоотойгоор хялгас ялгахаас дээш боловсруулалт хийх үйлдвэрүүдийн хүчин чадлыг тодорхойлох, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах Монгол Улсын Их Хурлын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны даргын 2023.10.27-ны өдрийн 06 дугаар тушаал гарсан. Уг ажлын хэсгийн ажлын хүрээнд ноос, ноолуурын үйлдвэрүүдтэй танилцаж, хүчин чадлыг тодорхойлох ажилд оролцож ажилласан. - Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж, Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулж батлуулах чиг үүрэг ЭЗХЯ-д шилжсэнтэй холбоотойгоор олон улсад мөрдөгдөж байгаа дунд хугацааны төсвийн хүрээ, төсвийн дунд хугацааны бодлогын талаар Олон улсын валютын сан, Дэлхийн банкны гаргасан судалгааны материал, Өмнөд Африкийн гарын авлага зэрэг холбогдох баримт бичиг, судалгааны материалуудыг судлан Монгол Улсад нэвтрүүлэх боломжтой эсэх | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | талаар судалсан. Энэ хүрээнд цаашид ажлын хэсэг байгуулах, холбогдох яамд байгууллагатай хамтарч ажиллах ажлууд төлөвлөгдөж байна. | |
| 3.3. | Эдийн засгийн нөхцөл байдал дүн шинжилгээ хийж, эдийн засагт тулгарч болзошгүй гадаад, дотоод эрсдэлийг тодорхойлно. | - | - | - | - | Эдийн засагт учрах эрсдэлийг дараах агуулгын хүрээнд судалж, Монгол Улсын 2024 оны төсвийн танилцуулгад тоймлон тусгасан. Үүнд, Орос-Украйны нөхцөл байдал, санхүүгийн салбарын эмзэг байдал, эрчим хүчний хангамж, мал, амьтны өвчин, цаг агаар, ган, зуд, тээвэр, логистикийн хүндрэл, дэлхий нийтэд хүнсний үнэ өсөх, зээлжих зэрэглэл буурах болон аливаа төрлийн хоригт орохоос сэргийлэх эрсдэлийг тус тус тусгасан болно. | 100% |
| 3.3.1 | Макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн статистикийн сарын гүйцэтгэлээр мэдээллийн сан үүсгэж, | Үйл ажиллагааны зардлаар | Мэдээллийн тоо | Түүхэн мэдээллийн сан үүсгэсэн. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Тухай бүр мэдээллээр хангасан байна. | Макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийн мэдээллийн санг сар бүр үүсгэн боловсруулж, удирдлагыг шуурхай | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | удирдлагыг тухай бүр мэдээллээр хангана. | | | | | мэдээллээр ханган ажиллав. Тухайлбал, бодит салбар, төсвийн тэнцэл, гадаад тэнцэл, мөнгөний салбар зэрэг 12 бүлэг бүхий 78 үзүүлэлтүүдийг сар, улирал, жилийн давтамжтай тоон мэдээллийн санг үүсгэж тухай бүр шинэчлэн ажилласан. Түүнчлэн, эдгээр тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийж, УИХ-ын чуулган, ЗГ-ын хуралдаан болон бусад хурал, уулзалтад шаардлагатай илтгэл, танилцуулга, мэдээллийг бэлтгэн тухай бүр удирдлагад танилцуулсан. | |
| 3.3.2 | Өдөр тутмын шуурхай мэдээлэл бэлтгэх, голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн мэдээллийн сан үүсгэж, удирдлагыг тухай бүр шуурхай мэдээллээр хангана. | Үйл ажиллагааны зардлаар | Мэдээллийн тоо | Түүхэн мэдээллийн сан үүсгэсэн. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Тухай бүр мэдээллээр хангасан байна. | Өдөр тутмын шуурхай тоон мэдээллийг 2023 оны 1-12 дугаар саруудад тухай бүр шинэчлэн, PowerApps апликэйшний тусламжтайгаар гар утас, зөөврийн компьютероор өдөр тутамд хандах боломжтой байдлаар удирдлагыг шуурхай мэдээллээр ханган ажиллав. Тухайлбал, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зэс, төмрийн хүдэр, нүүрс, газрын тос зэрэг түүхий эдийн голлох бүтээгдэхүүнүүдийн дэлхийн зах зээлийн болон экспортын үнэ, биет хэмжээ, гадаад зах зээл дээрх голлох индексүүд, манай улсын ЗГ-ын бондын ханш, дотоодын зах зээл дээрх албан, албан бус валютын ханш, хөрөнгийн зах дээрх томоохон компаниудын хувьцааны ханш болон мах, гурил, ногоо, сүү зэрэг гол нэрийн барааны үнэ зэргийг өдөр тутамд шинэчлэн хүргүүлж байна. | |
| 3.3.3 | Монгол Улсын эдийн засгийн эрсдэлийг тодорхойлж, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг болон төсвийн тухай хуулийн танилцуулгад тусгана. | Үйл ажиллагаан ы зардлаар | Эрсдэлийн судалгааны тоо | Суурь судалгаа дата үүсгэсэн. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Болзошгүй эрсдэлийн судалгаа боловсруулж, бодлогын баримт бичгүүдийн танилцуулгад тусгасан байна. | Монгол Улсын 2024 оны төсөв болон дунд хугацааны бодлогын баримт бичиг болох 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн танилцуулгад эдийн засгийн болзошгүй эрсдэлийг тоймлон тусгасан. Тухайлбал, Орос-Украйны дайны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нөхцөл байдал хүндэрсэн тохиолдолд манай улсын ОХУ, Европоос импортолдог стратегийн бүтээгдэхүүний нийлүүлэлт тасалдах, улмаар импортын бараа, бүтээгдэхүүний үнэ өсөх, үйлдвэрлэлийн зардал нэмэгдэх эрсдэл хэвээр байна. Санхүүгийн салбарын эмзэг байдлын эрсдэлийг авч үзвэл санхүүгийн салбарын тогтвортой байдал системийн нөлөө бүхий банкнуудын үйл ажиллагаанаас бүрэн хамаарч байгаа нь аливаа гадаад, дотоод эрсдэл үүссэн тохиолдолд банкны салбараар дамжин санхүүгийн салбарын тогтвортой байдал алдагдах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Эрчим хүчний суурилагдсан хүчин чадал төдийлөн нэмэгдээгүй, станцуудын насжилт өндөр байгаа нь оргил ачааллын үеэр нийлүүлэлтийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | доголдол, тасалдал үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Мал, амьтны халдварт өвчин, цаг агаарын таагүй нөхцөл, ган зудын эрсдэлт хүчин зүйлсээс шалтгаалан хөдөө аж ахуйн болон аялал жуулчлалын салбарын үйлдвэрлэл, бүтээмж төсөөлсөн хэмжээнээс бага байх эрсдэлтэй. Замын-Үүд боомтын ачааллаас шалтгаалан тээвэр, логистикийн хүндрэл үүсэх, улмаар богино, дунд хугацаанд тээврийн зардал нэмэгдсэнээр импортын барааны үнэ өсөж, инфляцын дарамт нэмэгдэх, стратегийн бүтээгдэхүүний тээвэрлэлт саатаж, бодит салбаруудын үйлдвэрлэлийн орц тасалдах, урт хугацаанд эдийн засгийн нийт бүтээмж буурах эрсдэл байна. Дээр дурдагдсан эрсдэлээс гадна дэлхий нийтэд хүнсний үнэ өсөх, зээлжих зэрэглэл буурах болон аливаа | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төрлийн хоригт орохоос сэргийлэх эрсдэлийг тус тус тусгасан болно. | |
| 3.4. | Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах бодлогын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор судалгааг хөгжүүлэхэд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангана. | - | - | - | - | Эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийн, судалгаан дээр үндэслэн Засгийн газраас 2024 онд баримтлах бодлого, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, Дэлхийн эдийн засгийн чуулганаас гаргадаг "Өрсөлдөх чадварын индекс"-ийн үзүүлэлтүүдийг ахиулах чиглэлээр тус тус дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэж, удирдлагуудад танилцуулж, ажилласан. Улмаар бодлогын санал, зөвлөмжүүдийг тодорхойлж, Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө, 2024 оны нэгдсэн төсвийн танилцуулга, Засгийн газрын 233 дугаар тогтоолд тусгасан. Тухайлбал, эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, экспортыг нэмэгдүүлэх, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зохицуулалтыг хялбарчлах, бизнесийг дэмжих, салбаруудын татааснаас чөлөөлж, цогц шинэчлэл хийх, хөрөнгө оруулалтыг дэмжиж, эдийн засгийг төрөлжүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэх чиглэлээр судалгаа хийн зорилт, арга хэмжээний саналыг тусгасан болно. | |
| 3.4.1 | Дата баазууд боловсруулж, эдийн засгийн судалгаанд ашиглана. (Гаалийн дата, и-баримт гэх мэт) | Үйл ажиллагааны зардлаар | Тайланд ашигласан тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Улирлын тайланд ашигласан байна. /3 удаа/ | Эдийн засгийн нөхцөл байдалд улирал (Macro diagnostics) тутмын танилцуулгад гаалийн дата, И-баримтын датаг боловсруулан гадаад худалдааны нөхцөл байдал, борлуулалтын нөхцөл байдалд шинжилгээ хийн тусгасан болно. Хавсралт: 3 файл | 90% |
| 3.4.2 | Эдийн засгийн бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон суурь судалгаа бүхий урт хугацааны эдийн засгийн хандлагын судалгааг боловсруулна. | Үйл ажиллагааны зардлаар | Судалгааны тоо | Судалгаанд шаардлагатай тоо мэдээллийг цуглуулсан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Судалгаа боловсруулсан байна. /1 тайлан/ | Эдийн засгийн хандлагын судалгаан дээр үндэслэн Монгол Улсын 2024 оны төсвийн танилцуулгад туссан Засгийн газраас 2024 онд баримтлах бодлого, тэргүүлэх чиглэлийг | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тодорхойлсон. Тухайлбал, эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, экспортыг нэмэгдүүлэх, зохицуулалтыг хялбарчлах, бизнесийг дэмжих, салбаруудын татаасныаас чөлөөлж, цогц шинэчлэл хийх, хөрөнгө оруулалтыг дэмжиж, эдийн засгийг төрөлжүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэх зорилтыг тусган холбогдох арга хэмжээний саналыг тусгасан.<br>Хавсралт: 3 файл | |
| 3.4.3 | Эдийн засгийн богино хугацааны идэвхжилийн тайлан бэлтгэж удирдлагад танилцуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Тайлангийн тоо | Тайланд шаардлагатай судалгааны тоон мэдээллийг цуглуулсан. | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: Тайлан боловсруулсан байна. /1 тайлан/ | Эдийн засгийн богино хугацааны идэвхжилийн тайланг гадаад зах зээл, үйлдвэрлэл, хөдөлмөрийн зах зээл, санхүүгийн зах зээл, эдийн засгийн хямралыг урьдчилан мэдээлэх индикаторын мэдээлэл зэрэг агуулгын хүрээнд боловсруулсан. | 90% |
| 3.5. | Өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийн олон улс | - | - | - | - | Өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийн олон | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дахь эрэмбийг ахиулах зорилгоор судалгаа, шинжилгээнд үндэслэн бодлогын нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангана. | | | | | улс дахь эрэмбийг ахиулах зорилгоор судалгаа, шинжилгээнд үндэслэн бодлогын нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах хүрээнд Дэлхийн улс орнуудын өрсөлдөх чадвар, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг хэмжиж буй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн голлох 53 индексүүдийн аргачлал, хэмжиж буй үзүүлэлтүүд, Монгол Улсын авч буй оноо, эрэмбийн мэдээллээр өгөгдлийн санг үүсгэн, Дэлхийн эдийн засгийн чуулганы "Өрсөлдөх чадварын индекс"-ийн үзүүлэлтүүдийг ахиулах чиглэлээр дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэж, удирдлагуудад танилцуулж, ажилласан. Түүнчлэн тус индексийн үнэлгээг сайжруулах чиглэлээр бодлогын санал, зөвлөмжүүдийг тодорхойлж, УХЖТ-2024, Төсөв бодлогын баримт бичигт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тусгасан. Мөн Авлигын төсөөллийн индекс болон Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн үзүүлэлтүүдээр Монгол Улсын олон улсад эзлэх эрэмбийг ахиулах чиглэлээр судалгаа, танилцуулга боловсруулж, олон нийтэд мэдээлэл хүргэн ажиллаж байна. | |
| 3.5.1 | Улсын өрсөлдөх чадварыг Дэлхийн эдийн засгийн чуулганаас гаргадаг "Өрсөлдөх чадварын индекс"-т тулгуурлан судалж, шаардлагатай тоон мэдээллийг цуглуулсан сан үүсгэж дүн шинжилгээ хийнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Өгөгдлийн сангийн тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Өгөгдлийн сан үүсгэсэн байна. /1 файл/ | Дэлхийн эдийн засгийн чуулганаас нэгтгэн гаргадаг "Өрсөлдөх чадварын индекс"-т дэлгэрэнгүй судалгаа хийж, Монгол Улсын өрсөлдөх чадварыг хойш татаж буй үзүүлэлтүүдийг ахиулах санал, зөвлөмжүүд боловсруулсан. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд эдийн засгийн тэргүүлэх чиглэл тодорхойлох ажлын хүрээнд санал зөвлөмж, бодлогын чиглэл тусгагдсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.5.2 | Өрсөлдөх чадварын индексийн олон улс дахь эрэмбийг ахиулах чиглэлээр санал боловсруулж, танилцуулга бэлтгэн удирдлагад танилцуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Танилцуулгын тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Танилцуулга боловсруулсан байна. /1 танилцуулга/ | Дэлхийн эдийн засгийн чуулганы "Өрсөлдөх чадварын индекс"-ийн үзүүлэлтүүдийг ахиулах чиглэлээр дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэж, удирдлагуудад танилцуулж, ажилласан. Түүнчлэн тус индексийн үнэлгээг сайжруулах чиглэлээр бодлогын санал, зөвлөмжүүдийг тодорхойлж, УХЖТ-2024, Төсөв бодлогын баримт бичигт тусгасан. Мөн Авлигын төсөөллийн индекс болон Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн үзүүлэлтүүдээр Монгол Улсын олон улсад эзлэх эрэмбийг ахиулах чиглэлээр судалгаа, танилцуулга боловсруулан ажиллаж байна. | 100% |
| 3.5.3 | Өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийг сайжруулах чиглэлээр олон нийтэд үнэн, зөв мэдээлэл хүргэж ажиллана. | Үйл ажиллагааны зардлаар | Олон нийтэд хүргэсэн мэдээллийн тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Олон нийтэд мэдээлэл хүргэсэн байна. /1 нийтлэл/ | Эдийн засаг, хөгжлийн яамны med.gov.mn веб сайтын "Мэдээ" хэсэгт "Эдийн засгийн тойм блог" цэс шинээр үүсгэж, Дэлхийн эдийн засгийн чуулганаас гаргадаг "Өрсөлдөх | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | чадварын индекс", Транспэрэнси Интернэшнлээс танилцуулдаг "Авлигын төсөөллийн индекс", Өв уламжлалын сангийн "Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс"-ийн талаар Монгол Улсын эзлэх байр, авсан оноо үнэлэгдсэн үзүүлэлтүүдийн талаарх нийтлэлүүдийг байршуулсан. | |
| 3.6. | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулна. | - | - | - | - | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйл 6.5, 9 дүгээр зүйлийн 9.4.2 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод үндэслэн дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих Хөгжлийн зорилтот хөтөлбөр (ХЗХ)-ийн төслийг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсруулсан. Үүнд: Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр, Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр, Байгаль орчны зорилтот хөтөлбөр, Засаглалын зорилтот хөтөлбөр, Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр, Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөр болно. ХЗХ-ийн төслийг боловсруулахдаа НҮБ-аас санаачилсан “Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөр”-тэй уялдуулж, үндэсний хэмжээний зорилго, зорилт, түүний хүрэх түвшин, хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон. “Тогтвортой хөгжлийн зорилтот хөтөлбөрийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтаар “Тогтвортой хөгжлийн зорилтот хөтөлбөр” Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн бодлогыг, 2 дугаар хавсралтаар Үндэсний болон салбарын үр дүнгийн хяналт- | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг, 3 дугаар хавсралтаар Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг тайлагнах шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг батлахаар боловсруулсан. Энэ удаагийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл нь дараах онцлог давуу талтай болно. Үүнд: - Хүлээгдэж буй үр дүнг үндэсний болон салбарын түвшнээр уялдуулан төлөвлөсөн; - Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг бүрэн тодорхойлсон; - Үр дүнд хүрэх арга замыг тодорхойлсон. | |
| 3.6.1 | Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслүүдийг боловсруулна. Үүнд: - Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр; - Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр; - Байгаль орчны зорилтот хөтөлбөр; - Засаглалын зорилтот хөтөлбөр; - | Үйл ажиллагааны зардлаар | Боловсруулах бодлогын баримт бичгийн тоо | Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын хавсралтаар "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг баталсан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Хөгжлийн 6 зорилтот хөтөлбөрийн төслийг боловсруулсан байна. /Нийт 6 бодлогын баримт бичиг/ | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйл 6.5, 9 дүгээр зүйлийн 9.4.2 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр; - Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөр. | | | | | 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод үндэслэн дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих Хөгжлийн зорилтот хөтөлбөр (ХЗХ)-ийн төслийг боловсруулсан. Үүнд: Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр, Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр, Байгаль орчны зорилтот хөтөлбөр, Засаглалын зорилтот хөтөлбөр, Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр, Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөр болно. ХЗХ-ийн төслийг боловсруулахдаа НҮБ-аас санаачилсан “Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөр”-тэй уялдуулж, үндэсний хэмжээний зорилго, зорилт, түүний хүрэх түвшин, хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон. “Тогтвортой хөгжлийн зорилтот хөтөлбөрийг батлах тухай” Улсын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Их Хурлын тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтаар “Тогтвортой хөгжлийн зорилтот хөтөлбөр” Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн бодлогыг, 2 дугаар хавсралтаар Үндэсний болон салбарын үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг, 3 дугаар хавсралтаар Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг тайлагнах шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг батлахаар боловсруулсан. Энэ удаагийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл нь дараах онцлог давуу талтай болно. Үүнд: - -Хүлээгдэж буй үр дүнг үндэсний болон салбарын түвшнээр уялдуулан төлөвлөсөн; - -Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг бүрэн тодорхойлсон. - -Үр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүнд хүрэх арга замыг тодорхойлсон. | |
| 3.6.2 | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийн эхний хувилбарыг боловсруулна. | Үйл ажиллагааны зардлаар | Боловсруулах төлөвлөлтийн баримт бичгийн тоо | Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр" батлагдсан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн төслийн эхний хувилбарыг боловсруулсан байна. /Нийт 1 баримт бичиг/ | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэлийн дагуу Эдийн засаг, хөгжлийн сайдаас 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 01/1028 дугаартай “Санал ирүүлэх тухай” албан бичгийг бүх сайд нарт хүргүүлсэн. “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн төслийг боловсруулж, яамны удирдлагуудад танилцуулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар бэлтгэв. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан зорилго, зорилтод нийцүүлэн, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Шинэ сэргэлтийн бодлогод үндэслэн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөтөлбөрийн төслийг боловсрууллаа. Мөн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах зарчимд нийцүүлэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг нэгдмэл, цогц, харилцан уялдаатай, залгамж чанартай, үр дүнд чиглэсэн байдлаар тодорхойлж, салбарын болон төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, тэргүүлэх төсөл, арга хэмжээ, түүнийг хэмжих хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тусгалаа. Үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд Засгийн газраас 2024-2028 онд баримтлах бодлогын чиглэлийг дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тулгуурлан Эдийн засаг болон дэд бүтцийн хөгжил, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Үндэсний өрсөлдөх чадвар, Хүний хөгжил, Нийгмийн хөгжил, Ногоон хөгжил, Засаглал, Бүс, орон нутгийн хөгжил гэсэн 7 бүлгийн хүрээнд зорилго, зорилтуудыг тодорхойлов. Үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтийг бодлогын үндэслэл, салбарын болон төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, хэрэгжүүлэх арга зам, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин, мэдээллийн эх үүсвэр, хариуцагч байгууллага тус бүрээр тодорхойлов. | |
| 3.6.3 | Богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг буюу "Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө"-ний төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ. | Үйл ажиллагаан ы зардлаар | Боловсруулах төлөвлөлтийн баримт бичгийн тоо | Улсын Их Хурлын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 23 дугаар тогтоолын хавсралтаар "Монгол Улсын хөгжлийн 2023 оны | Эхний хагас жилд: "Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө"-ний төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна. /Нийт 1 төлөвлөлтийн баримт бичиг/ Жилийн эцэст: - | Монгол Улсын төсвийн суурь төлөвлөлтийн баримт бичиг болох Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төслийг боловсруулан, Засгийн газрын 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанаар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | төлөвлөгөө"-г баталсан. | | хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэв. Улмаар Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төслийг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, 39 дүгээр тогтоолоор батлууллаа. Төлөвлөгөөний төсөлд салбарын яамд, байгууллагууд, орон нутгийн захиргааны байгууллагаас 2024 онд хэрэгжүүлэхээр нийт 80.2 их наяд төгрөг бүхий 1047 төсөл, арга хэмжээний санал ирүүлсэн. Төлөвлөгөөний төслийг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдуулан боловсруулав. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төслийг өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгыг дэвшүүлж, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 6 бүлэг, бодлогын тэргүүлэх 8 чиглэлийн хүрээнд нийт 13.99 их наяд төгрөгийн санхүүжилт бүхий 194 төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэмжих 100 шалгуур үзүүлэлттэй боловсруулсан. Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төслийн онцлог нь үр дүнд суурилсан төлөвлөлтийн арга зүйг шинээр нэвтрүүлсэнд оршино. Тус аргачлал нь салбарын болон хөтөлбөрийн үр дүнг тодорхойлох, тухайн төсөл арга хэмжээний хүрэх үр дүн, тэдгээрийг хэмжих шалгуур үзүүлэлт, шаардагдах хөрөнгийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэмжээ, эх үүсвэрийг бодитой төлөвлөх ач холбогдолтой болсон. | |
| 3.6.4 | Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн үндэсний сайн дурын 2 дахь илтгэлийн төслийг боловсруулна. | Үйл ажиллагааны зардлаар | Боловсруулах илтгэлийн төслийн тоо | Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн үндэсний сайн дурын 1 дэх илтгэлийн төслийг 2019 онд боловсруулж, НҮБ-ын улс төрийн дээр хэмжээний уулзалтад танилцуулсан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн үндэсний сайн дурын 2 дахь илтгэлийн төслийг боловсруулж, НҮБ-ын Улс төрийн дээд хэмжээний чуулга уулзалтад танилцуулсан байна. | Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны 9 дүгээр 30-ны өдрийн А/92 дугаар тушаалаар Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, иргэний нийгмийн төлөөллийн оролцоотой Үндэсний сайн дурын илтгэл бэлтгэх Ажлын хэсгийг байгуулан ажилласан. Илтгэлийг боловсруулахдаа 1) ТХЗ-ын хэрэгжилтийн ахиц, дэвшлийг үнэлэх арга зүй, 2) Бүс, орон нутгийн хөгжлийн шинжилгээний арга зүй, 3) Боломжийн тэгш бус байдлын шинжилгээний арга зүйг тус тус ашигласан бөгөөд олон талын оролцоог хангах хүрээнд 10 гаруй удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, үр дүнг тусган удиртгал, 6 бүлэг, дүгнэлт, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цаашид авах арга хэмжээний санал гэсэн бүтэцтэй боловсруулсан. Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн үндэсний сайн дурын 2 дахь илтгэлийг 2023 оны 6 дугаар сурын 7-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж, НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлд 2023 оны 6 дугаар сарын 9-ний өдөр хүргүүлсэн. Улмаар АНУ-ын Нью-Йорк хотноо 2023 оны 7-р сарын 10-аас 20-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Тогтвортой хөгжлийн асуудлаарх Улс төрийн өндөр түвшний чуулга уулзалтад Эдийн засаг, хөгжлийн дэд сайдын түвшинд “Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн үндэсний сайн дурын 2 дахь илтгэл” /ҮСДИ/-ийг танилцуулсан. Илтгэлдээ анхны ҮСДИ-ийн дүгнэлт зөвлөмжийн хэрэгжилт хөгжлийн бодлогуудад хэрхэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | туссан тухай болон тогтвортой хөгжлийн нэгдмэл, цогц, оновчтой систем бий болгохын тулд нийгмийн бүхий л талын оролцоог хангах механизм нэн чухал болохыг онцолсон юм. | |
| 3.7. | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлж улс, салбар, салбар хооронд нэгтгэн зохион байгуулах, уялдааг хангах, арга зүйн зөвлөгөө өгнө. | - | - | - | - | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.6-т заасны дагуу хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд шаардагдах журмын төслийг холбогдох яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагатай хамтран боловсруулж, Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 470 дугаар тогтоолоор “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журам”-ыг шинэчлэн баталсан. Тус журмын 1.2-т “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг болон Улсын хөрөнгө оруулалтын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөтөлбөр боловсруулах заавар, аргачлал, загварыг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн онцлог, хуулиар тогтоосон тавигдах шаардлагад нийцүүлэн баримт бичиг тус бүрээр батлахаар заасан. Энэ журмын дагуу Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/167 дугаар тушаалаар “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн А/25 дугаар тушаалаар "Хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах аргачлал"-ыг, 2023 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн А/26 дугаар тушаалаар "Хөгжлийн зорилтот хөтөлбөр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсруулах аргачлал"-ыг тус тус батлуулав. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлж, улс, салбар, салбар хооронд нэгтгэн зохион байгуулж, уялдааг хангаж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. | |
| 3.7.1 | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд шаардагдах журмын төслийг боловсруулна. | Үйл ажиллагаан ы зардлаар | Боловсруулах журмын төслийн тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Холбогдох журмын төслийг боловсруулсан байна. /Нийт 1 журмын төсөл/ | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.6-т заасны дагуу хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд шаардагдах журмын төслийг холбогдох яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагатай хамтран боловсруулж, Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 470 дугаар тогтоолоор “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журам”-ыг шинэчлэн баталсан. Тус журмын 1.2-т “Хөгжлийн бодлого, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөвлөлтийн баримт бичиг болон Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах заавар, аргачлал, загварыг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн онцлог, хуулиар тогтоосон тавигдах шаардлагад нийцүүлэн баримт бичиг тус бүрээр батлахаар заасан. Энэ журмын дагуу Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/167 дугаар тушаалаар “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн А/25 дугаар тушаалаар "Хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах аргачлал"-ыг, 2023 оны 5 дугаар сарын 8- | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ны өдрийн А/26 дугаар тушаалаар "Хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах аргачлал"-ыг тус тус батлуулав. | |
| 3.7.2 | Улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгнө. | Үйл ажиллагаан ы зардлаар | 2024 оны улсын төсвийн төсөлд зөвшөөрөл өгсөн байх. | Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар 2022 онд зөвшөөрөл өгсөн. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Монгол Улсын 2024 оны төсвийн төсөл Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд нийцсэн эсэхийг нягтлан шалгаж, зөвшөөрөл өгсөн байна. | Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд нийцсэн эсэхийг нягтлан шалгаж, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 01/1788 дугаар албан бичгээр зөвшөөрлийг олгов. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.7.3 | Олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн хөгжлийн судалгааны байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтоох, үндэсний хэмжээнд бодлого, төлөвлөлтийн хүний нөөцийг сургах, чадавхжуулна. | Үйл ажиллагаан ы зардлаар | Хүний нөөцийг чадавхжуулах сургалт зохион байгуулах, хувиар | Хүний нөөцийг чадавхжуулах сургалтыг тухай бүр, зохион байгуулсан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Хүний нөөцийг чадавхжуулах сургалт зохион байгуулсан байна. /100 хувь/ | 1.ЕХ-ны санхүүжилтээр НҮБХХ-ийн хэрэгжүүлж буй “Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь” төслийн зөвлөхүүд болон ЭЗХЯ-ны Нэгдсэн бодлогын газрын хамтарсан баг 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 08-ны өдөр Дорноговь аймагт “Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй” сэдэвт сургалт, аргачлал турших ажлыг удирдамжийн дагуу амжилттай зохион байгуулав. Энэхүү сургалт, аргачлал турших ажлын үр дүнд Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлалын төслийг сайжруулж, батлуулав. 2.Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/26 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүрдүүлдэг баримт бичгийн тоог цөөрүүлэх, давхардлыг арилгах, үйл ажиллагаанд зарцуулж буй хугацаа болон зардлыг бууруулах арга хэмжээг авч ажилласан. Мөн тогтоолын хүрээнд уул уурхайн бус бүтээгдэхүүний салбарын экспортыг дэмжих бодлогын баримт бичиг, хуулийн төслийг боловсруулан, батлуулах бэлтгэлийг хангаад байна. Мөн худалдааны түнш улс орнуудтай худалдааны тэнцлийг сайжруулж, эргэлтийг нэмэгдүүлэх хүрээнд чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг байгуулах үйл ажиллагааг зохион байгуулахын зэрэгцээ Монгол Улсын нэгдэн орсон худалдааны олон улсын хэлэлцээрүүдийн хэрэгжилтийг сайжруулахаар ажиллаж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.21.3 | Худалдааны үндсэн үзүүлэлтүүдийн статистик мэдээллийг тухай бүр гаргаж, мэдээллийн сан үүсгэн хөгжүүлж, мэдээллийг эргэлтэд оруулна. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Мэдээллийн сан үүсгэж, статистик мэдээллийг тухай бүр гаргаж, эргэлтэд оруулсан байна. /100 хувь/ | Худалдааны үндсэн үзүүлэлтүүдийн статистик мэдээллийг тухай бүр гарган, мэдээллийн сан үүсгэн хөгжүүлж, мэдээллийг эргэлтэд оруулах чиглэлээр гүйцэтгэсэн. - Гаалийн ерөнхий газрын гадаад худалдааны статистик мэдээллийг эх сурвалж болгон Монгол Улсын экспорт, импортоор тус тус тэргүүлэгч 10 улсын мэдээллийг жил, сараар тогтмол шинэчлэн гаргаж албан хэрэгцээнд ашигласан/гаргасан. - Төрийн дээд хэмжээний болон Засгийн газрын хоорондын албан уулзалтад шаардлагатай 25 улсын гадаад худалдаа, экспорт, импортын дүн бүхий мэдээллийг тухай бүрд нь дэлгэрэнгүй гаргасан. Ингэхдээ тухайн улсуудтай хийсэн сүүлийн жилүүдийн импорт, экспортын дүн, барааны нэр төрөл, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эзэлж буй хувь хэмжээ, гэрээ хэлэлцээрийн товч мэдээлэл зэргийг бэлтгэв. - Засгийн газраас гаргасан шийдвэрүүд гадаад худалдаанд хэрхэн нөлөөлж буй талаар судалгаа шинжилгээ хийсэн. Тухайлбал уул уурхайн бус бүтээгдэхүүний сүүлийн жилүүдийн тоон мэдээллийг мах, махан бүтээгдэхүүн, ноос ноолууран бүтээгдэхүүн, арьс ширэн бүтээгдэхүүн, самар зэрэг бүтээгдэхүүнээр дэлгэрэнгүй тайлан гаргасан. - Манай улсын сар бүрийн экспорт, импортын үнийн дүнг бүлгийн код (HS2)-оор, тэргүүлэгч 5-6 улсаар тус тус харьцуулан гаргасан. - ОХУ болон БНСУ-ын хэлэлцээртэй холбоотойгоор гадаад худалдааны мэдээллийг барааны бүлэг бүрээр, бусад улсын экспорт, импорттой харьцуулан гаргасан болно. - | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Засгийн газрын хуралдаанд асуудал танилцуулахад шаардлагатай тоон мэдээллийг танилцуулга, инфографик хэлбэрээр тухай бүр бэлтгэж ажиллав. - Гадаад худалдааны мэдээллийг гаалийн боомт, барааны нэр төрөл, орц хэмжээ, үнийн дүнгээр 2018 оноос 2023 оны 08 сар хүртэлх хугацаагаар дэлгэрэнгүй байдлаар гаргасан. - Худалдааны үндсэн үзүүлэлт бүхий статистик мэдээллийг сар бүр шинэчилж, мэдээллийн сан үүсгэсэн ба бусад хэлтэс, газар ашиглах боломжтойгоор байгууллагын дотоод сүлжээнд байршуулав. | |
| 3.21.4 | Экспорт, импортын үйл ажиллагааны нөхцөл байдлыг судлан, худалдаанд учирч буй техникийн саад бэрхшээлийг тодорхойлж, тэдгээрийг багасгах, худалдааг хөнгөвчлөхөд чиглэсэн | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Тухай бүр судалгаа хийн, дүгнэлт гаргаж, санал боловсруулсан байна. /100 хувь/ | Худалдааны эргэлтийг хязгаарлаж буй саад тотгорыг арилгаж, худалдааг чөлөөлөх хүрээнд арьс, ширний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт болон | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бодлого боловсруулан, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангаж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлнэ. | | | | | Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтад заасан экспорт, импортын үйл ажиллагаанд тавьж буй шаардлага, хязгаарлалтуудын хугацааг хойшлуулах, хүчингүй болгох тухай Засгийн газрын тогтоол шийдвэрүүдийг гаргуулсан. Ямааны ноолуурын хувьд 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс угаасан ноолуурын экспортыг хориглосон шийдвэрийг 2022 онд гаргаад байсан. Ноолуурын экспортод хориг тавьснаар ноолуурын үнэ, малчдын орлого буурах зэрэг олон эрсдэл үүсээд байв. Эдгээр эрсдэлийн улмаас Засгийн газар 2023 оны 2 дугаар сард ноолуурын экспортыг хориглосон шийдвэрийг 2024 оны 7 дугаар сар хүртэл түдгэлзүүлэх асуудлыг Засгийн газарт танилцуулж шийдвэрлүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Улмаар дотоодын зах зээл дээрх ноолуурын үнэ 2023 оны хавар 119,200 төгрөг болж буюу өмнөх оны мөн үеэс 11.2 мянгаар өссөн. Арьс ширний экспортыг 2013 онд хориглох шийдвэр гаргаж түүнээс хойш 2015, 2016, 2019, 2020, 2023 онуудад түр түдгэлзүүлсэн 5 удаагийн шийдвэр гаргаж байжээ. Мөн ноолуурын экспортыг хориглосон шийдвэр гарснаас хойш 4 сарын дараа шийдвэрийг мөн түдгэлзүүлсэн. Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний экспортыг хориглосон эсвэл түр хугацаанд зөвшөөрсөн эдгээр шийдвэрүүд нь тус салбарын бүтээгдэхүүнүүдийн гадаад худалдааны сүлжээг доголдуулж, улмаар эрэлт болон үнэд сөргөөр нөлөөлж, малчдын орлогыг бууруулж, ядуурлыг нэмэгдүүлэх бодит эрсдэлийг бий болгож байна. Иймд арьс шир, ноолуурын экспортыг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хориглосон техникийн зохицуулалтын зохицуулалтыг хүчингүй болгох Засгийн газрын тогтоолыг 2023 оны 10 дугаар сарын 11-нд гаргуулсан. | |
| 3.21.5 | Худалдааны эрх зүйн зохицуулалтын орчныг судалж, бодит нөхцөл байдалтай уялдуулан сайжруулахад чиглэсэн бодлого боловсруулан, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангаж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Тухай бүр судалгаа хийж, бодит нөхцөл байдалтай уялдуулан бодлого боловсруулсан байна. /100 хувь/ | Гадаад худалдааны орчин, экспортын үйл ажиллагааг сайжруулж, худалдааг хөнгөвчлөх чиглэлээр бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх хүрээнд “Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 178 дугаар тогтоолыг батлуулсан. Тогтоолын хүрээнд Уул уурхайн бус бүтээгдэхүүний салбарын экспортыг дэмжих чиглэлээр хуулийн төслийг боловсруулж, хэлэлцүүлэхээр төлөвлөгөө гарган ажиллаж байна. Хуулийн төсөл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсруулах хэрэгцээ, шаардлагыг судалж тандан судалж тайланг гаргасан бөгөөд хуулийн төсөл, үзэл баримтлалын төслийг боловсруулан анхны хэлэлцүүлгийг 2023.10.13-нд зохион байгуулсан. Уг хуулиар ашигт малтмалын хайлт, ашиглалт, олборлолт баяжуулалт зэрэг үйл ажиллагаа хамаарахгүй жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих харилцааг зохицуулна. Хуулийн төсөл батлагдсанаар уул уурхайн бус салбарын бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, экспортлох таатай, тогтвортой орчин бүрдэж, төрөөс үзүүлэх дэмжлэгийн хэлбэр, хамрах хүрээ, дэмжлэгт хамрагдах этгээд, процессыг тодорхой болгох ач холбогдолтой. | |
| 3.21.6 | "Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системийг бүрэн нэвтрүүлж, гадаад худалдаанд холбогдох | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: Тухай бүр дэмжлэг үзүүлж ажилласан байна. /100 хувь/ | Гадаад худалдаа эрхлэгчид экспорт хийхэд 16-аас дээш тооны баримт бичгийг бүрдүүлж, дунджаар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төрийн үйлчилгээг хялбаршуулахад дэмжлэг үзүүлнэ. | | | | | 168 цаг зарцуулдаг бөгөөд нэг мэдээллийг дунджаар 12 удаа давхардуулан илгээдэг, зарим төрлийн мэдээллийг цахимаар илгээх боломжгүй зэрэг нь гадаад худалдаанд үүсэж буй томоохон саад тотгорыг судлан, “Гадаад худалдааны цахим нэг цонх”-ны системийг 2024 онд хэрэглээнд бүрэн нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн. Тус системийг нэвтрүүлж гадаад худалдааны явцад бүрдүүлдэг баримт бичгийн тоог цөөрүүлэх, давхардлыг арилгах, үйл ажиллагаанд зарцуулж буй хугацаа болон зардлыг бууруулах чиглэлээр холбогдох байгууллагуудын оролцоог хангаж, ажлын хэсэг байгуулахаар Сангийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Гаалийн ерөнхий газарт нэр авах тухай Эдийн засаг, хөгжлийн яамны 2023 оны 6 дугаар сарын 28-ны | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өдрийн 03/1154 тоот албан бичгийг хүргүүлэн хариуг авч ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн хүрээнд тодорхой үүрэг даалгаврыг өгч, судалгааг хийлгэн мэдээлэл солилцсон. Иргэн, хуулийн этгээдээс шаарддаг бичиг баримт, бүрдүүлбэрийн судалгааг холбогдох байгууллагуудаас авч нэгтгэв. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар ажлын хэсгийг хуралдуулахаар бэлтгэл ажлыг хангасан ба 2023 оны 10 дугаар сарын 20-нд хуралдсан. Хурлаар дараах асуудлыг хөндөн ярилцаж тохиролцсон болно. Үүнд: - RIBS төсөл, ГЕГ, ЭЗХЯ-ны гурван талт уулзалт хийж ажлын эхлэх цэгийг тодорхой болгох; - Тогтоолыг хэрэгжүүлэх журмыг хамтран боловсруулах; - Ажлын даалгаврын төслийг ГЕГ-аас | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хариуцан боловсруулах, ажлын даалгаврыг ажлын хэсгийн гишүүдэд тараах санал авах, улмаар ажлын төлөвлөгөөг батлах. Гадаад худалдааны цахим нэг цонхны системийг бий болгох ажлын санхүүжилтийг Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл /RIBS/ -ийн хүрээнд зээлийн санхүүжилтээр шийдвэрлүүлэхээр тооцоо судалгааг хийж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн түүнчлэн АХБ-ны Бест төслийн хүрээнд хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх талаар судалж байна. | |
| 3.21.7 | Гадаад худалдааны явцад бүрдүүлдэг баримт бичгийн тоог цөөрүүлэх, давхардлыг арилгах, үйл ажиллагаанд зарцуулж буй хугацаа болон зардлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авч ажиллана. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/ | Гадаад худалдааны явцад бүрдүүлдэг баримт бичгийн тоог цөөрүүлэх, давхардлыг арилгах, үйл ажиллагаанд зарцуулж буй хугацаа болон зардлыг бууруулах зорилтын хүрээнд Засгийн газрын 2023 оны 178 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар тогтоолын төслийг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан. ."Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системийг бий болгох, гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагааг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан эхлүүлэхээр ажиллаж байна. Ингэснээр иргэн, хуулийн этгээдэд гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг үзүүлэхэд төрийн мэдээллийн үндсэн системээр дамжуулан авах, солилцох боломжтой мэдээллийг давхардуулан шаардахгүй байх боломж бүрдэх юм: Мөн түүнчлэн тус тогтоолын хүрээнд бүтээгдэхүүн, үйлчилгээ баталгаажуулалтын байгууллагын тоог нэмэгдүүлэх, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний хариу, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тохирлын гэрчилгээ, гарал үүслийн гэрчилгээ, мал эмнэлгийн гэрчилгээг цахим хэлбэрээр олгодог болохоор ажиллаж байна. "Цахим нэг цонх" системийг нэвтрүүлснээр экспортын гаалийн бүрдүүлэлтэд зарцуулагддаг цаг хугацааг 3-4 дахин, импортын хувьд 2-3 дахин багасгах тооцоо гаргасан. Түүнчлэн Засгийн газрын 2023 оны 233 дугаар тогтоолд худалдааг хөнгөвчилж, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх чиглэлд дараах арга хэмжээг тусган хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Үүнд: Хөдөө аж ахуйн биржээр арилжаалсан бараа, түүхий эдийн тодорхойлолтын маягт болон бараа, түүхий эдийн тодорхойлолт олгох асуудлыг хөнгөвчлөх, үйлчилгээний хөлсний хэмжээг бууруулах талаар холбогдох арга хэмжээ авч | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжүүлэх, Худалдаа эрхлэгч Гаалийн ерөнхий газарт олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг хүргүүлж, мал эмнэлгийн ариун цэврийн гэрчилгээ авч байгаа давхардсан зохицуулалтыг хүчингүй болгох талаар судалж, зохих арга хэмжээ авах, Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт”-ыг шинэчлэх ажлыг шуурхай зохион байгуулсан. | |
| 3.22. | Монгол Улсын нэгдэн орсон, байгуулсан олон талт болон хоёр талт гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтийн үр ашгийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авах, хэрэгжилтэд хяналт тавина. | - | - | - | - | 1. Монгол Улсын нэгдэн орсон, байгуулсан олон талт болон хоёр талт хэлэлцээр (ДХБ, APTA, Монгол-Японы EPA), ЕХ-ны Хөнгөлөлтийн ерөнхий систем (GSP+) бүрэн ашиглах чиглэлээр холбогдох судалгааг хийсэн. 2. Монгол Улсын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Ерөнхий сайдын 2023 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 55 дугаар захирамжаар “Монгол Улс, БНСУ хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах ажлыг удирдан зохион байгуулах Ажлын хэсэг” байгуулагдсан. Уг захирамжаар Солонгосын талтай хэлэлцээ хийх Монголын багийг томилж, баримтлах удирдамжийг батлан ажиллуулахыг Ажлын хэсэг (Ч.Хүрэлбаатар)-т даалгасны дагуу “Хэлэлцээний баг”-ийг Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны А/47 дугаар тушаалаар байгуулсан. Энэ хүрээнд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хамрах хүрээ, зорилго, талуудын үүрэг хариуцлагыг тодорхойлсон Ажлын даалгаврын төслийг Солонгосын талтай харилцан санал солилцсоны үндсэн дээр эцэслэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсруулж, хоёр талын Хэлэлцээний багийн ахлагч нар 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан. Уг Ажлын даалгаварт гарын үсэг зурснаар Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн яриа хэлэлцээг албан ёсоор эхлүүлсэн бөгөөд талууд хэлэлцээрийн эхний шатны хэлэлцээг 2023 оны 12 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд БНСУ-ын Сөүл хотноо зохион байгуулахаар харилцан тохиролцож, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 3. Монгол Улсаас ОХУ-д нийлүүлж буй бараа бүтээгдэхүүнд ногдуулж буй татварын хэмжээг бууруулах, худалдаан дахь техникийн саад тотгорыг багасгах зорилгоор Чөлөөт худалдааны түр хэлэлцээр байгуулах асуудлаар ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн яамтай хамтран түр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэлэлцээрийн төсөлд Монголын талын байр суурь, саналыг хүргүүлэхээр холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. | |
| 3.22.1 | Олон улсын худалдааны хөгжлийн чиг хандлага, гадаад, дотоод нөхцөл байдлын талаар мэдээлэл цуглуулан, судалгаа хийж, удирдлагыг мэдээллээр хангана. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/ | ОХУ болон БНСУ-тай байгуулахаар төлөвлөж буй хэлэлцээрүүдтэй холбоотойгоор тус улсуудтай гадаад худалдаа хийсэн бараа бүтээгдэхүүний мэдээллийг бусад улсын экспорт, импорттой харьцуулан гаргасан. Монгол Улсаас бусад орнуудад нийлүүлэх боломжит бараа бүтээгдэхүүний хүчин чадлын хэмжээний талаарх мэдээлэл, хэлэлцээрийн хүрээнд гаалийн татварын хөнгөлөлттэй нөхцөлөөр экспортлох боломжтой бараа бүтээгдэхүүний судалгааг хийж, холбогдох мэдээллийг гаргасан. | 100% |
| 3.22.2 | Монгол Улсын нэгдэн орсон, байгуулсан, шинээр байгуулах олон | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Тухай бүр | 1. Монгол Улсын нэгдэн орсон, байгуулсан олон талт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | талт болон хоёр талт гэрээ, хэлэлцээрийг хэрхэн үр дүнтэй ашиглах, тэдгээрийн хүрээнд гадаад худалдааны тэнцлийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авч ажиллана. | | | | шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/ | болон хоёр талт хэлэлцээр (ДХБ, АРТА, Монгол-Японы ЕРА), ЕХ-ны Хөнгөлөлтийн ерөнхий систем (GSP+) бүрэн ашиглах чиглэлээр холбогдох судалгааг хийсэн. 2. Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 55 дугаар захирамжаар “Монгол Улс, БНСУ хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах ажлыг удирдан зохион байгуулах Ажлын хэсэг” байгуулагдсан. Уг захирамжаар Солонгосын талтай хэлэлцээ хийх Монголын багийг томилж, баримтлах удирдамжийг батлан ажиллуулахыг Ажлын хэсэг (Ч.Хүрэлбаатар)-т даалгасны дагуу “Хэлэлцээний баг”-ийг Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны А/47 дугаар тушаалаар байгуулсан. Энэ хүрээнд Эдийн засгийн түншлэлийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэлэлцээрийн хамрах хүрээ, зорилго, талуудын үүрэг хариуцлагыг тодорхойлсон Ажлын даалгаврын төслийг Солонгосын талтай харилцан санал солилцсоны үндсэн дээр эцэслэн боловсруулж, хоёр талын Хэлэлцээний багийн ахлагч нар 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан. Уг Ажлын даалгаварт гарын үсэг зурснаар Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн яриа хэлэлцээг албан ёсоор эхлүүлсэн бөгөөд талууд хэлэлцээрийн эхний шатны хэлэлцээг 2023 оны 12 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд БНСУ-ын Сөүл хотноо зохион байгуулахаар харилцан тохиролцож, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 3. Монгол Улсаас ОХУ-д нийлүүлж буй бараа бүтээгдэхүүнд ногдуулж буй татварын хэмжээг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бууруулах, худалдаан дахь техникийн саад тотгорыг багасгах зорилгоор Чөлөөт худалдааны түр хэлэлцээр байгуулах асуудлаар ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн яамтай хамтран түр хэлэлцээрийн төсөлд Монголын талын байр суурь, саналыг хүргүүлэхээр холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. | |
| 3.22.3 | Худалдаа, эдийн засаг, санхүүгийн асуудлаар түнш орон, олон улсын болон бүс нутгийн эдийн засгийн байгууллагууд, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллана. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/ | 1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Монгол Улсын Засгийн газар, Женев хотноо төвтэй Олон улсын худалдааны төвтэй хамтран 20 дахь удаагийн “Дэлхийн экспортыг дэмжих чуулга уулзалт”-ыг 2023 оны 06 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулсан. Чуулга уулзалтад дэлхийн 70 орчим улс орноос 600 гаруй төлөөлөгчид оролцож, ногоон эдийн засаг, худалдаа, экспортыг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дэмжих, жижиг дунд бизнес эрхлэгчид, тэр дундаа эмэгтэйчүүд бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, цахим шийдлүүдийг санал болгох, сурталчлах болон бүс нутаг, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, шинэ зах зээл, шинэ боломжуудын талаар хэлэлцэн санал солилцсон. 2. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын ээлжит 25 дугаар хуралдааныг 2023 оны 10 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулсан. Комиссын энэ удаагийн хуралдаанаар Монгол Улс, Оросын Холбооны Улсын харилцаа, хамтын ажиллагаанд тулгамдаж буй цаг үеийн асуудлууд, тэр дундаа Монгол Улсын бараа бүтээгдэхүүнүүдийг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Оросын Холбооны Улсад гаргах нөхцөлийг хөнгөвчлөх, худалдааны эргэлтийг нэмэгдүүлж төрөлжүүлэх, экспортыг өргөжүүлж худалдааны алдагдлыг бууруулах, Оросын талтай түлш, эрчим хүчний салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, хөдөө аж ахуй, байгаль орчин, боловсрол, соёлын харилцааны хэвийн байдлыг хадгалах, шинэ боломжуудын талаар хэлэлцэн, протокол байгуулсан. 3. Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хооронд 1992 онд байгуулсан Техникийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд 2 жилт тутамд 1 удаа зохион байгуулдаг Хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны ээлжит хэлэлцээг 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.23. | Чөлөөт бүсийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг тодорхойлох, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг хангуулж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж, хяналт тавина. | - | - | - | - | Алтанбулаг, Замын-Үүд, Цагааннуур чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, түүнтэй уялдуулан техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, тэргүүлэх чиглэл тодорхойлох зэрэг холбогдох судалгааны ажлуудыг гүйцэтгэгч компаниудаар хийж гүйцэтгүүлж байна. Эдгээр судалгааны ажлууд, техник эдийн засгийн үндэслэл, тэргүүлэх чиглэлүүд тодорхойлсноор хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө тодорхой болж чөлөөт бүсийн хөгжлийн бодлого тодорхойлогдоно. Эдгээр судалгааны ажлыг улсын төсөв болон донор байгууллага, олон улсын байгууллагын дэмжлэг туслалцаатайгаар хэрэгжүүлж байна. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.23.1 | Бодлогын төсөл боловсруулахад шаардлагатай судалгаа хийнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Судалгааны тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Судалгаа хийж, дүгнэлт гаргасан байна. /1 судалгаа/ | Чөлөөт бүсийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн төсөл боловсруулах ажлын хүрээнд ОХУ, БНХАУ, БНТУ, БНКУ, БНСУ-ын чөлөөт бүсүүд, Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг амжилттай хэрэгжүүлэх үүднээс Хятад-Казакстаны Олон улсын хил орчмын хамтын ажиллагааны “Хоргос” төв зэргийг судалгаа хийж дүгнэлт гаргасан. Харин ОХУ-тай хамтран эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах ажлын хүрээнд Алтанбулаг чөлөөт бүсийг үргэлжлүүлэн хөгжүүлэх, хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх, хилийн зорчигч болон тээврийн хөдөлгөөн, худалдааны эргэлтэд үндэслэн баруун бүсэд Боршоо боомтыг эдийн засгийн хамтын ажиллагааны бүс, худалдааны бүс | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болгон хөгжүүлэх, зүүн бүсэд Эрээнцав боомтыг түшиглэн зүүн бүсийн өсөн нэмэгдэж буй хэрэглээ, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төлөв байдалд үндэслэн тээвэр логистикийн хамтын ажиллагааны бүс болгон хөгжүүлэх боломжийн талаар санал боловсруулсан. Алтанбулаг, Цагааннуур чөлөөт бүсүүдийн техник эдийн засгийн үнэлгээ хийх, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлуудыг хийж гүйцэтгэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөн ажиллаж, зөвлөх компанийн гүйцэтгэлд хяналт тавин ажилласан. Замын-Үүд чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулсан ТГТ ХХК-ийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж дүгнэлт гарган яамны | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | удирдлагуудад танилцуулж тус ажлыг хүлээн авах боломжгүйг тогтоон, шинээр хийж гүйцэтгэх ажлын даалгаврыг боловсруулан Барилга, хот байгуулалтын сайдаар батлуулахаар бэлтгэж байна. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын Комиссын 25 дугаар хуралдааны баримт бичиг, протокол, арга хэмжээний төлөвлөгөөнд "Алтанбулаг чөлөөт бүсэд хамтран ажиллах “замын зураглал” боловсруулж, тохирч, хэрэгжүүлж эхлэх" заалтыг тусгуулсан. | |
| 3.23.2 | Чөлөөт бүсийг хөгжүүлэх бодлого, чиглэлийг тодорхойлон, төсөл боловсруулж, холбогдох бодлогын баримт бичгүүдэд тусгуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/ | Алтанбулаг, Цагааннуур, Замын-Үүд, Хөшигийн хөндийн чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд техник эдийн засгийн урьдчилсан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | судалгаа хийж чөлөөт бүсүүдийн хөгжлийн бодлого, чиглэлийг судалгаа, шинжилгээнд үндэслэн тодорхойлох ажлыг гүйцэтгэгч компанийн судлаачид, чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албадтай хамтран ажиллаж байна. Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсийг хөгжүүлэх чиглэлээр төслийн санал боловсруулж Япон улсын ЖАЙКА байгууллагаар дэмжигдэн "Шинэ зуун мод хот болон эдийн засгийн чөлөөт бүсийн хөгжлийн дэмжих" төслийг хэрэгжүүлэхээр Санамж бичиг байгуулсан. Тус төслийн ажил 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр төслийг хэрэгжүүлэх Япон талын зөвлөхүүд ЭЗХЯ-тай уулзсанаар албан ёсоор эхлээд байна. Төсөл хэрэгжсэнээр эдийн засгийн чөлөөт бүсийн хууль эрх зүйн орчин, хөрөнгө оруулалт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | татах аргачлал, чөлөөт бүсийн менежмент, институтийн тогтолцоо зэрэг асуудлаар дүгнэлт зөвлөмж гаргах юм. Замын-Үүд чөлөөт бүсэд хэрэгжүүлж буй Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгийн эх үүсвэртэй "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл"-ийг эрчимжүүлэх ажлын хүрээнд Төслийн нэгжийг шинэчлэн байгуулсан. Төслийн багц ажлуудыг хэрэгжүүлэх хүрээнд Чөлөөт бүсийн менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулаад байна. Мөн Хилийн удирдлагын нэгдсэн системийг хөгжүүлэх ажлын даалгаврын гүйцэтгэгчийн эцсийн тайланг хүлээн авч холбогдох байгууллагуудыг оролцуулсан хурал зохион байгуулсан. Мөн Хятадын талын Эрээний чөлөөт бүсийн асуудал | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хариуцсан байгууллагатай шууд харилцаж төлөвлөгөө уялдуулахаар ажиллаж байна. Мөн Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн Монголын талын хамтарсан гүйцэх зөвлөлийн хурлыг зохион байгуулж 2 талын хурлыг зохион байгуулах саналаа хятадын талд хүргүүлэн ажиллаж байна. Чөлөөт бүсийг хөгжүүлэхэд шаардлагатай төсөл, хөтөлбөрийн саналыг Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд суулгах, шаардлагатай төсвийг Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсөвт тусгасан. | |
| 3.23.3 | Чөлөөт бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан хууль, эрх зүйн орчныг сайжруулахад чиглэсэн хууль тогтоомжийн тандан судалгаа хийнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Судалгааны тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Судалгаа хийж, дүгнэлт гаргасан байна. /Нийт 1 судалгаа/ | Чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын хүрээнд Чөлөөт бүсийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид дүн шинжилгээ, давхцал хийдлийн судалгаа | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хийсэн. Мөн Азийн хөгжлийн банк, Гүрж, Филиппин, БНХАУ-ын зөвлөхүүдтэй хамтран “Монгол Улсын чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх” зөвлөгөөнийг зохион байгуулж Чөлөөт бүс байгуулах, үйл ажиллагааг зохицуулах бодлого, хууль тогтоомж, дүрэм журмыг боловсронгуй, оновчтой болгож, шинэчлэх шаардлагатай дүгнэлт гаргасан. Дүн шинжилгээний үр дүнд Чөлөөт бүсэд мөрдөх нийтлэг журам байхгүй, чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх, тамхи худалдах зөвшөөрлийг зохицуулж байсан журмууд нь эрх зүйн мэдээллийн санд бүртгэлгүй, мөн эдгээр журмууд нь шинээр батлагдсан Зөвшөөрлийн тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тухай хууль зүйн шаардлагад нийцээгүй зэрэг нөхцөл байдал илэрсэн. Иймд чөлөөт бүсийн хууль эрх зүйн орчныг сайжруулах ажлын хүрээнд "Чөлөөт бүсэд мөрдөх нийтлэг журам", “Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журам”, “Чөлөөт бүсэд тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх энгийн зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журам”-ын төслийг Захиргааны ерөнхий хуулийн холбогдох шаардлагуудыг ханган боловсруулсан. Олон улсын санхүүгийн төв байгуулах тухай хуулийн төслийг боловсруулсан. Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсийг хөгжүүлэх ажлын хүрээнд төслийн санал | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсруулж Япон улсын ЖАЙКА байгууллагаар дэмжигдэн "Шинэ зуун мод хот болон эдийн засгийн чөлөөт бүсийн хөгжлийн дэмжих" төслийг хэрэгжүүлэхээр Санамж бичиг байгуулсан. 2023.12.13-ны өдөр төслийн Япон талын зөвлөхүүд ЭЗХЯ-тай уулзалт хийсэн. Төсөл хэрэгжсэнээр эдийн засгийн чөлөөт бүсийн хууль эрх зүйн орчин, хөрөнгө оруулалт татах, чөлөөт бүсийн менежмент, институтийн тогтолцоо зэрэг асуудлаар дүгнэлт зөвлөмж гаргаж хууль эрх зүйн орчныг сайжруулна. | |
| 3.23.4 | Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан эдийн засгийн чөлөөт бүсийг үе шаттайгаар нээх судалгаа хийж, төлөвлөлтийн төсөл боловсруулна. | Үйл ажиллагааны зардлаар | Судалгааны тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Төлөвлөлтийн төсөл боловсруулсан байна. /Нийт 1 төсөл/ | Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан баруун болон зүүн бүсэд эдийн засгийн чөлөөт бүс байгуулах боломжийн талаар судалгаа хийсэн. Судалгааны үр дүнд баруун бүсэд Боршоо боомтын хилийн зорчих хөдөлгөөн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болон бараа эргэлтэд түшиглэн эдийн засгийн хамтын ажиллагаа бүс эсвэл худалдааны чөлөөт бүс байгуулах, зүүн бүсэд өсөн нэмэгдэж буй тээврийн хэрэгцээ шаардлага, транзит тээврийг хөгжүүлэх боломжид тулгуурлан Эрээнцав боомтыг түшиглэн тээвэр логистикийн чөлөөт бүс байгуулах боломжтой талаар санал боловсруулж танилцуулсан. Олон улсын зэрэглэлийн АН-4 авто зам ашиглалтад орж Хятад-Монгол-Орос улсын шууд тээвэр хийгдэж эхэлсэнтэй холбогдуулан Цагааннуур чөлөөт бүсийн тэргүүлэх чиглэл, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр үүссэн нөхцөл байдалтай уялдуулах хэрэгцээ шаардлагын хүрээнд зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан компанитай уулзаж холбогдох чиглэлийг өгч ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | баруун таван аймгийн дотоодын түүхий эдийн нөөц боломж, импортын бараа бүтээгдэхүүний зах зээл зэрэг эдийн засгийн нөхцөл байдлыг судалснаар тус чөлөөт бүсийг өргөжүүлэх боломжийг эрэлхийлж байна. Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын хуралдаанаар цаашид хамтран эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах ажлын хэсэг байгуулахаар санал солилцон ажиллаж байна. Алтанбулаг, Цагааннуур, Замын-Үүд чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд төлөвлөлтийн төслийн саналтай танилцаж чөлөөт бүсийн бодлого, төлөвлөлтийн чиглэлийн саналыг тусган, яаралтай батлуулах чиглэлээр гүйцэтгэгч компани болон Захирагчийн ажлын албадтай | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамтран ажиллаж байна. | |
| 3.24. | Өндөр технологи, үндэсний инновацын тогтолцоог хөгжүүлэх нэгдсэн бодлогыг тодорхойлно. | - | - | - | - | Тухайн ажлыг гүйцэтгэх хугацаа болоогүй бөгөөд 2024 оны гүйцэтгэлийн тайланд тайлагнана | 50% |
| 3.24.1 | Өндөр технологи, үндэсний инновацын тогтолцооны урт, дунд хугацааны бодлого боловсруулж, төлөвлөлт хийнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Боловсруулсан баримт бичгийн тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Өндөр технологи, үндэсний инновацын тогтолцооны урт, дунд хугацааны бодлого боловсруулж, төлөвлөлт хийсэн байна. /1 баримт/ | Монгол Улс Дэлхийн инновацын индексээр 2023 онд 68-т жагссан хэдий ч зах зээлийн орчны индексээрээ дэлхийд 101-т эрэмбэлэгдсэн. Манай улсын Хөрөнгө оруулалтын түвшнийг тодорхойлох үзүүлэлтүүд гарахгүй байгаа нь Монгол Улсын индексд сөрөг үр дагавартай байна. Эдгээр үзүүлэлтүүдийг гаргах, бүх индексийг сайжруулан байр ахиулахад чиглэсэн дунд, урт хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулахаар судалгаа хийж байна. | 90% |
| 3.24.2 | Үндэсний инновац бодлогын хөгжлийн асуудлаар хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох | Үйл ажиллагааны зардлаар | Төслийн тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Боловсруулсан байна. /1 баримт бичиг/ | Үндэсний инновацын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох, үнэлэх аргачлалыг боловсруулах, дэлхийд өрсөлдөх | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | санал, дүгнэлт боловсруулна. | | | | | инновацын үзүүлэлтүүдийг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн батлагдсан Инновацын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар төлөвлөн хуулийн төслийг боловсруулах ажлыг эхлүүлээд байна. "Инновацын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл 2025-2030"-д тусгах үйл ажиллагааг тодорхойлохоор судалгааны ажил болон бусад арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. | |
| 3.24.3 | Үндэсний инновацын хөгжлийн түвшнийг үнэлэх аргачлал боловсруулна. | Үйл ажиллагааны зардлаар | Боловсруулах аргачлалын тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Боловсруулсан байна. /1 баримт бичиг/ | Үндэсний инновацын хөгжлийн түвшнийг үнэлэх аргачлал боловсруулахаар Дэлхийн инновацын индексийг тодорхойлсон тайланг жишиг болгон судалгааны ажлыг хийж байна. Судалгаагаар Монгол Улс нь Дэлхийд инновацын индексээр 2022 онд 74-р эрэмбэлэгдэж байсан | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бол 2023 онд 68-д болж 7 шатаар ахиж бүсийн зэрэглэлээрээ 13-т жагссан байна. - Төрийн байгууллагын индексээр дэлхийд 80-д эрэмбэлэгдэж байна. - Дэд бүтцийн индексээр 81-т эрэмбэлэгдэж байна. - Мэдээлэл технологийн индексээр 88 дугаарт, бүтээлч байдлаараа Дэлхийн индексийн түшингээр 40-т эрэмбэлэгдэж байна. - Хүний нөөц, ажиллах хүчний индексээр 65-д эрэмбэлэгдэж байгаа бөгөөд үүнээс боловсролын зарим салбарын хөгжлийн түвшнийг тодорхойлон гаргадаггүй мөн Бизнесийн орчин индексээр Дэлхийд 67-т эрэмбэлэгдэж үүнээс бизнесийн судалгааны хөгжлийн түвшнийг тодорхойлон гаргадаггүй байгаа нь Монгол Улсын индексийн түвшнийг тодорхойлоход сөрөг үр дагавартай байна. | |
| 3.25. | Инновацын үйл ажиллагаанд | - | - | - | - | ЭЗХЯ-ны дотоод нөөц бололцоонд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | оролцогчдыг нэгдсэн арга зүй, удирдлагаар хангана. | | | | | тулгуурлан сервер, тоног төхөөрөмж, дотоод сүлжээний бүтэц зохион байгуулалтад үнэлгээ хийж зөвлөмж гаргасан. - Яамны мэдээллийн аюулгүй байдал, кибер халдлагаас урьдчилан сэргийлэх журмын төсөл боловсруулав. - Албан бичгийн программ хангамжийг сайжруулан Төрийн албан бичиг солилцооны системтэй холбох ажлыг гүйцэтгэв. - Яамны хэмжээнд firewall ажиллуулан аюулгүй байдлыг хангаж, Үндэсний аудитын газрын шалгалтад хамруулав. - Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)-н Монгол дахь төлөөлөгчийн газраас зохион байгуулж буй MICS-2023 хөтөлбөрийн MID-TERM EVENT, EuroChamber Innovation and Digitalization 2023-10-06-ны өдөр, Монголын Инновацын 7 хоног / | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Mongolian Innovation Week 2023-06-05-с 12-ны өдөр эрэг арга хэмжээнд оролцож мэдээллээр хангаж ажиллав. - Эдийн засаг, хөгжлийн яамны дотоод нөөц бололцоонд тулгуурлан сервер зохион байгуулж, төрийн мэдээлэл солилцооны ХУР системтэй холболт хийх гэрээ байгуулан, холболтыг хийв. ГЕГ-ын мэдээллийн сантай холболт хийсэн. ЭЗХЯ-ны албан хаагчдад зориулсан платформын хөгжүүлэлт эхэлсэн. | |
| 3.25.1 | Үндэсний инновац, өндөр технологийн талаарх судалгаа шинжилгээ хийх, судалгаа, шинжилгээнд суурилан үндэсний инновацын тэргүүлэх чиглэлийг тодорхойлно. | Үйл ажиллагааны зардлаар | Боловсруулсан баримт бичгийн тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Баримт бичиг боловсруулсан байна. /1 баримт бичиг/ | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 95 дугаар тогтоолоор "ИННОВАЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2020-2025" батлагдсан. "ИННОВАЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2025-2030"-ын 2024 онд багтаан батлуулахаар энэ | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | жилээс судалгааны ажлыг эхлүүлэх арга хэмжээ болон бусад оролцогч нартай уулзалт хийж байна. Яамны ахмад ажилтан Бат-Эрдэнэтэй (Шинжлэх ухаан, технологийн чиглэлийн төрийн бус байгууллагын тэргүүнээр ажиллаж байгаа) 2 удаагийн уулзалт хийж, санал солилцов. | |
| 3.25.2 | Үндэсний инновацын бодлого, төлөвлөлтийн хүрээнд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдэд арга зүйн дэмжлэг үзүүлнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Хэрэгжүүлсэн байна. /3 төсөл/ | 1. Монголын Инновацын 7 хоног / Mongolian Innovation Week 2023 оны 6-р сард зохион байгуулагдсан арга хэмжээнд оролцогчоор оролцож Инновац технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Стартапп компаниудтай уулзалтад оролцов. 2. EuroChamber Innovation and Digitalization 2023-10-06 өдөр зохион байгуулсан арга хэмжээнд оролцогчоор оролцож Инновац технологийн чиглэлээр үйл | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагаа явуулж буй Стартапп компаниудтай уулзалт хийв. 3. Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)-н Монгол дахь төлөөлөгчийн газраас зохион байгуулж буй MICS-2023 хөтөлбөрийн MID-TERM EVENT - хөтөлбөрт оролцож дэмжлэг арга зүй туслалцаа үзүүлсэн. Монгол Улсын Засгийн газраас “Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний 10 жилийн хэрэгжилтийг хангах “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг төр, хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын идэвхтэй түншлэлд тулгуурлан Монгол Улсын хөгжлийг хязгаарлаж буй зургаан багц асуудлуудыг шийдвэрлэхээр ажиллаж байна. Мөн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжүүлэхэд чиглэсэн 2 дахь 10 жилийн цогц бодлогын баримт бичгийг уул уурхай голлосон хөгжлөөс шинжлэх ухаан, технологи, инновацад суурилсан хөгжлийг тэргүүлэх чиглэл болгон, бүх салбарт технологи, инновацын шилжилт хийх зорилт, арга хэмжээг тусган боловсруулах "Ажлын хэсэг"-ийг байгуулсан. MICS-2023 хөтөлбөрийн зорилт болох дотоод болон гадаадын олон талын оролцогчдын мэдлэг, хөрөнгө, инновацыг нэгтгэх замаар хамтын бүтээлийг бий болгож, ногоон хөгжлийг дэмжих агуулга нь манай яамны тэргүүлэх чиглэлүүдээр тусгагдсан үйл ажиллагаануудтай нягт уялдаатай юм. | |
| 3.25.3 | Хувь хүн, хуулийн этгээдэд үндэсний инновац, өндөр технологийн талаар мэдлэгийг дээшлүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Арга хэмжээг хэрэгжүүлсэн байх, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Сургалтад хамрагдсан байна. /3 сургалт/ | 1. Монголын Инновацын 7 хоног / Mongolian Innovation Week 2023 оны 6-р сард зохион байгуулсан арга | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | арга хэмжээ зохион байгуулна. | | | | | хэмжээнд оролцогчоор оролцож Инновац технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Стартапп компаниудтай уулзалтад оролцов. 2. EuroChamber Innovation and Digitalization 2023-10-06 өдөр зохион байгуулсан арга хэмжээнд оролцогчоор оролцож Инновац технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Стартапп компаниудтай уулзалтад оролцов. 3. Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)-н Монгол дахь төлөөлөгчийн газраас зохион байгуулж буй MICS-2023 хөтөлбөрийн MID-TERM EVENT - хөтөлбөрт оролцож арга зүй, ханган, дэмжлэг үзүүлэв. Монгол Улсын Засгийн газраас “Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний 10 жилийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжилтийг хангах “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг төр, хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын идэвхтэй түншлэлд тулгуурлан Монгол Улсын хөгжлийг хязгаарлаж буй зургаан багц асуудлуудыг шийдвэрлэхээр ажиллаж байна. Мөн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн 2 дахь 10 жилийн цогц бодлогын баримт бичгийг уул уурхай голлосон хөгжлөөс шинжлэх ухаан, технологи, инновацад суурилсан хөгжлийг тэргүүлэх чиглэл болгон, бүх салбарт технологи, инновацын шилжилт хийх зорилт, арга хэмжээг тусган боловсруулах "Ажлын хэсэг"ийг байгуулсан. MICS-2023 хөтөлбөрийн зорилт болох дотоод болон гадаадын олон талын оролцогчдын мэдлэг, хөрөнгө, инновацыг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэгтгэх замаар хамтын бүтээлийг бий болгож, ногоон хөгжлийг дэмжих агуулга нь манай яамны тэргүүлэх чиглэлүүдээр тусгагдсан үйл ажиллагаануудтай нягт уялдаатай юм. | |
| 3.26. | Үндэсний инновацын хөгжлийн түвшнийг үнэлэх аргачлал боловсруулах, мөрдүүлэх, хууль тогтоомж хөтлөхөөр заасан мэдээллийн сангуудын чиг үүргийг хэрэгжүүлнэ. | - | - | - | - | Яамны дотоод сүлжээ, серверийг зохион байгуулалтад оруулан эрх бүхий албан хаагчийг хандах боломжоор ханган ажиллаж байна. - Яамны дотоод Кибер аюулгүй байдлыг хангах журам боловсруулав. - “Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа, мэдээлэл өгөх журам” -ын төслийг бэлтгэн Засгийн газрын 2023 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 251 дүгээр тогтоолоор батлуулсан. - Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар Зөвшөөрлийг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цахимаар олгох ажлыг эрчимжүүлэх 30 дугаар тэмдэглэлийн төслийг танилцуулж эрхлэх асуудал, хариуцсан салбарын хүрээний тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэр гаргах үйл ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн цахим хэлбэрт шилжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгаж, зөвшөөрөл олгох эрх бүхий холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд зөвлөв. - Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдаанаар "Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2023 оны 233 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцыг танилцуулсан. - Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийн боловсруулалтад оролцон ажилласан. -Энгийн болон тусгай 363 зөвшөөрлийг олгодог эрх бүхий 30 байгууллагын 190 албан хаагчдад зөвшөөрлийн мэдээлэл оруулах эрх нээж 2023 оны 09 дүгээр сарын 28-ны байдлаар 21089 зөвшөөрлийн мэдээлэл бүртгээд байна. Зөвшөөрлийн нэгдсэн санд мэдээлэл оруулах албан хаагчдад цахим болон танхимын сургалт явуулж, гарын авлага бэлтгэн гаргасан. | |
| 3.26.1 | Мэдээллийн нэгдсэн сангуудын үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн санал боловсруулна. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: -Жилийн эцэст: Хэрэгжүүлсэн байна. /3 төсөл/ | Яамны дотоод сүлжээ, серверийг зохион байгуулалтад оруулан эрх бүхий албан хаагчийг хандах боломжоор хангасан. Яамны дотоод сүлжээ, аюулгүй байдлыг хангах хүрээнд "Кибер аюулгүй байдлыг хангах журам" боловсруулан | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | батлуулахаар бэлэн болоод байна. | |
| 3.26.2 | Зөвшөөрлийн мэдээллийн нэгдсэн сангийн талаарх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал, дүгнэлт боловсруулна. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Хэрэгжүүлсэн байна. /3 төсөл/ | - "Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа, мэдээлэл өгөх журам" -ын төслийг бэлтгэн Засгийн газрын 2023 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 251 дүгээр тогтоолоор батлуулсан. - Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар Зөвшөөрлийг цахимаар олгох ажлыг эрчимжүүлэх 30 дугаар тэмдэглэлийн төслийг танилцуулж эрхлэх асуудал, хариуцсан салбарын хүрээний тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэр гаргах үйл ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн цахим хэлбэрт шилжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гишүүдэд даалгаж, зөвшөөрөл олгох эрх бүхий холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд зөвлөж ажилласан. - Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдаанаар "Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2023 оны 233 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцыг танилцуулсан. - Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийн боловсруулсан. | |
| 3.26.3 | Зөвшөөрлийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, холбогдох судалгаа, тооцооллыг хийнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Хэрэгжүүлсэн байна. /3 төсөл/ | Энгийн болон тусгай 363 зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэр гаргах үйл ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн цахим хэлбэрт шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвшөөрөл олгох эрх бүхий 30 байгууллагатай хамтран ажиллаж байна. -2023 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 21,085 зөвшөөрлийн мэдээлэл бүртгээд байна. -Зөвшөөрлийн цахим систем License.mn-д Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-т тусгагдаагүй 222 зөвшөөрөл бүртгэсэн байсныг холбогдох байгууллагуудтай хамтран идэвхгүй болгосон. -Хуульд зааснаас өөр нэршлээр бүртгэгдсэн 223 зөвшөөрлийг засаж, 132 тусгай зөвшөөрөл, 89 энгийн зөвшөөрлийн нэршлийг тус тус нэмсэн. -Зөвшөөрөл, түүнийг цахим хэлбэрээр олгохтой холбоотойгоор иргэн, хуулийн этгээдээс ирсэн санал, гомдлыг холбогдох байгууллагууд руу уламжилж, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шийдвэрлүүлэн ажиллаж байна. | |
| 3.26.4 | Зөвшөөрлийн нэгдсэн санд нэгдсэн байгууллага, нэгж, албан тушаалтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Хэрэгжүүлсэн байна. /3 төсөл/ | Энгийн болон тусгай 363 зөвшөөрлийг олгодог эрх бүхий 30 байгууллагын 190 албан хаагчдад зөвшөөрлийн мэдээлэл оруулах эрх нээж 2023 оны 09 дүгээр сарын 28-ны байдлаар 21089 зөвшөөрлийн мэдээлэл бүртгэгдээд байна. Зөвшөөрлийн нэгдсэн санд мэдээлэл оруулах албан хаагчдад цахим болон танхимын сургалт явуулж, гарын авлага бэлтгэн гаргаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. | 100% |
| 3.26.5 | Мэдээллийн сангуудын нууцлал, хамгаалалт, аюулгүй байдлын хангана. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Хэрэгжүүлсэн байна. /3 төсөл/ | ЭЗХЯ-ны дотоод нөөц бололцоонд тулгуурлан сервер, тоног төхөөрөмж, дотоод сүлжээний бүтэц зохион байгуулалтад үнэлгээ хийж зөвлөмж гаргасан. "Яамны мэдээллийн аюулгүй байдал, кибер халдлагаас урьдчилан сэргийлэх журам"-ын төсөл боловсруулж, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | батлуулахад бэлэн болсон. Албан бичгийн программ хангамжийг сайжруулан Төрийн албан бичиг солилцооны системтэй холбох ажлыг гүйцэтгэв. Яамны хэмжээнд firewall ажиллуулан аюулгүй байдлыг хангаж, Үндэсний аудитын газрын шалгалтад хамруулсан. | |
| 3.26.6 | Мэдээллийн сангийн бүрдүүлэлт, ашиглалтыг оновчтой болгох, технологи-инновац нэвтрүүлэх, суурь болон төрөлжсөн сангийн уялдаа холбоо, нийцэл, нэгдмэл байдлыг хангана. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Хэрэгжүүлсэн байна. /3 төсөл/ | Эдийн засаг, хөгжлийн яамны дотоод нөөц бололцоонд тулгуурлан сервер зохион байгуулж, төрийн мэдээлэл солилцооны ХУР системтэй холболт хийх гэрээ байгуулан, холболтыг хийж гүйцэтгэж байна. ГЕГ-ын мэдээллийн сантай холболт хийж, ЭЗХЯ-ны албан хаагчдад зориулсан платформын хөгжүүлэлт хийж байна. MS office 365 -ын хүрээний POWER APPs ашиглан өдөр тутмын мэдээний АПП | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөгжүүлэн ашиглагдаж байна. | |
| Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | |
| 4.1. | Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, газрын үйл ажиллагааг нэгтгэн төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, захиргааны нийтлэг үйлчилгээ, санхүү, аж ахуйн асуудлыг зохицуулна. | - | - | - | - | Яамны хэмжээний хүний нөөцийн хэвийн үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж ажилласан. Үүнд. Ажлаас чөлөөлөх, томилох, шилжүүлэх тушаалыг боловсруулж батлуулсан. Засгийн газрын 241 тогтоолын дагуу албан хаагчдын цалингийн шатлалын шинэчлэн гаргасан. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хүрээнд шинээр хүүхэдтэй болсон МЭЗБГ-ын ахлах мэргэжилтэн Х.Мөнхжавхлан, НБТГ-ын дарга Л.Балчинлувсан, шинээр гэр бүл болсон шинээр хүүхэдтэй болсон ХЭЗХАБГ-ын мэргэжилтэн Р.Болорцэцэг, ТЗУГ-ын ахлах мэргэжилтэн Ч.Нарангэрэл, Г.Энхцацрал, ТЗУГ-ын ахлах шинжээч С.Манлайдуламын эмчилгээнд, НБТГ-ын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.3.2 | Яамны эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих шийдвэр, албан бичгийн төслүүдийг боловсруулж, хянана. | Үйл ажиллагаан ы зардлаар | Төслийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих шийдвэр, албан бичгийн төслүүдийг тухай бүр боловсруулж, хянасан байна. /100 хувь/ | 1/Хуулийн хэлтсээс Эдийн засаг, хөгжлийн яаманд хандаж ирүүлсэн албан бичиг болон яамны бусад зохион байгуулалтын нэгжүүдээс санал авахаар ирүүлсэн дотоод бичиг нийт 775 албан бичгийг хууль тогтоомжид заасан хугацаанд шийдвэрлэж зохих хариуг хүргүүлсэн байна. Үүнээс гадагшаа чиглэсэн 487 албан бичиг, 278 дотоод бичиг, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 10 өргөдөл, гомдлыг тус тус шийдвэрлэж, холбогдох төслийг боловсруулж, хянаж, албажуулсан. 2/ Эдийн засаг, хөгжлийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | яамны Хуулийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтод заасны дагуу тус яамнаас гарч байгаа нийт албан бичгийн эргэлтэд хяналт тавьж, албан бичиг, тушаал, шийдвэрийн төслүүдийг тухай бүр хууль тогтоомж, Монгол хэлний үг, үсэг, найруулга зүйн хүрээнд хянаж байна. 3/Сайдын болон Төрийн нарийн бичгийн даргын тушаал, шийдвэрийн төслийг боловсруулах, бусад нэгжүүдээс ирүүлсэн төслийг хянах ажил үүргийг тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна. | |
| 4.3.3 | Байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журмын төслийг боловсруулна. | Үйл ажиллагаан ы зардлаар | Дүрэм, журмын тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Яамны хөдөлмөрийн дотоод журам, орон сууцны журмыг шинэчлэн боловсруулсан байна. /2-3 журам/ | Энэхүү ажлын хүрээнд дор дурдсан Дотоод хэм хэмжээний актын төслийг боловсруулсан болно. 1/ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3-т заасан "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний стандарт загвар" -ийн төслийг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсруулж, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн даргад хүргүүлсэн; 2/Эдийн засаг, хөгжлийн яамны Архив, албан хэрэг хөтлөлтийн журмын төсөлд бүтцийн нэгжүүдийн саналыг авч, нэгтгэн боловсруулж, танилцуулгын хамт удирдлагад хүргүүлэхээр бэлтгэж байна; 3/Мэдээллийн технологийн аюулгүй байдлыг хангах журмын төслийг боловсруулан Инновацын бодлогын газарт хүргүүлсэн бөгөөд зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдээс санал авах ажиллагаа хийгдэж байна; 4/ "Яамны зохион байгуулалтын нэгжийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам"-ын төсөлтэй танилцаж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газартай хамтран ажилласан. 5/Эдийн засаг, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөгжлийн яамны нийт албан хаагчдын гаргаж буй захиргааны хэм хэмжээний актыг журамлах үүднээс "Захиргааны хувийн хэрэг хөтлөх журам"-ыг боловсруулан Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. | |
| 4.3.4 | Долоо хоног бүрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудалд ЭЗХЯ-наас хүргүүлсэн саналуудын жагсаалтыг нэгтгэн боловсруулна. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 2023 оны III-IV улиралд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг тухай бүр гаргасан байна. /100 хувь/ | 1/ Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудал тус бүрд яамны зүгээс хүргүүлсэн хариуг нэгтгэн боловсруулж, удирдлагыг мэдээллээр хангах ажлыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. 2/ Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд яамнаас Засгийн хуралдаанаар орох дараах асуудлыг тухай бүр хариуцан гүйцэтгээд байна. Үүнд: 1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн дагалдах хууль тогтоомжийн төсөл болох 1/Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 2/Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 3/Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай; 2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон түүний үзэл баримтал; 3. Чөлөөт бүсэд архи, согтууруулах ундаа худалдаалахтай холбоотой ажлын хэсэгт ажиллах, хууль зүйн дүгнэлт гаргасан; 4.Уул уурхайн бус экспортыг дэмжих тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцох, үндэслэл бүхий санал боловсруулж хүргүүлсэн; 5.Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрыг Эдийн засаг, хөгжлийн яамны харьяанд шилжүүлэхтэй холбоотой хууль тогтоомжийн төсөл, танилцуулгыг бэлтгэж, Хөрөнгө оруулалтын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бодлогын газарт хүргүүлсэн, 6/Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн тандан судалгаа болон холбогдох баримтуудыг боловсруулахад оролцсон | |
| 4.3.5 | Яамны хэмжээнд байгуулагдаж буй гэрээний нэгдсэн бүртгэл хөтлөх, дугаар олгох, архив үүсгэнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Яамны хэмжээнд байгуулагдаж буй гэрээний нэгдсэн бүртгэл хөтлөх, дугаар олгох, архив үүсгэх ажиллагааг тухай бүр хийж гүйцэтгэсэн байна. /100 хувь/ | 1/Эдийн засаг, хөгжлийн яамнаас 2023 онд байгуулсан давхардсан тоогоор нийт 165 гэрээний төслийг боловсруулах, хянаж бүртгэх ажлыг зохион байгуулсан ба үүнээс Хуулийн хэлтсийн зүгээс Сайдын 2023 оны А/51 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулах 131 төсөл, арга хэмжээ"-ний 69 гүйцэтгэгчтэй холбогдох гэрээг хариуцан байгуулсан байна. 2/ Тус яамнаас 2023 онд байгуулсан нийт гэрээний хэрэгжилтийг үнэлэх, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | архивлах ажлыг 2023 оны 12 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөж, хэрэгжилтийн судалгааг гаргаж эхэлсэн байна. | |
| 4.3.6 | Эдийн засаг, хөгжлийн яамны 2023 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, яамны нэгжүүдийг авлигын эсрэг мэдээллээр хангана. | Үйл ажиллагаан ы зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Яамны авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг гаргах, албан хаагчдыг сургалтад хамруулах /100 хувь/ | Эдийн засаг, хөгжлийн яамны 2023 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 02 дугаар сарын 08-ны өдөр Авлигатай тэмцэх газрын хөтөлбөр бүртгэх сайтад бүртгүүлэн Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан бөгөөд төлөвлөгөөнд дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөнд заасанчлан яамны нийт албан хаагчдыг 2 удаагийн сургалтад хамруулсан. Төлөвлөгөөний тайланг Авлигатай тэмцэх газарт хуульд заасан хугацаанд буюу 12 дугаар сарын 15-нд хүргүүлнэ. Мөн Авлигын эсрэг 110 самбарыг тогтмол шинэчлэн ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.3.7 | ХАСХОМ-ийг хуульд заасан хугацаанд гаргуулах, бүртгэх, баталгаажуулна. | Үйл ажиллагаан ы зардлаар | Хуулийн хугацаанд мэдүүлсэн байх, хувиар | 2022 онд албан хаагчид 100 хувь мэдүүлсэн. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Хуулийн хугацаанд нийт албан хаагчид мэдүүлсэн байна. /100 хувь/ | 2023 оны 11 дүгээр сарын байдлаар давхардсан тоогоор 120 албан хаагчийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Мөн Авлигын эсрэг хуульд заасан Шинээр томилогдсон, Хөрөнгө орлогод их хэмжээний өөрчлөлт орсон болон шинэчлэн мэдүүлсэн /2 сарын 15-ны дотор/ зэрэг үндэслэлээр яамны нийт албан хаагчдын Хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулан бүртгэж баталгаажуулсан. | 100% |
| 4.3.8 | Нууцын асуудлыг эрхлэн хөтөлнө. | Үйл ажиллагаан ы зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Тухай бүр хөтөлсөн байна. /100 хувь/ | Эдийн засаг, хөгжлийн яамны нууцын асуудлыг эрхлэн хөтлөх ажлын хүрээнд: - 2023 онд нийт 118 нууц албан бичиг ирж, 68 нууц албан бичигт хариуг хүргүүлсэн. - 2023.05.11-ний өдрийн 03/795 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яамны нууцын зэрэгтэй бичиг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | баримттай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг хүргүүлсэн. - 2023.05.17-ны өдрийн 09/567 дугаартай албан бичгээр Тагнуулын ерөнхий газраас Эрх олгох тухай албан бичиг ирүүлсэн бөгөөд дээрх албан хаагчдад нууцын зэрэгтэй бичиг баримттай танилцах эрх олгосон болно. - 2023.05.25-ны өдөр Эдийн засаг, хөгжлийн сайдын А/34 дугаар тушаалаар “Эдийн засаг, хөгжлийн яамны албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-ыг баталсан. Тус жагсаалтыг боловсруулахдаа нэгжүүдээс санал авч бүрэн тусгасан бөгөөд Тагнуулын ерөнхий газраар хянуулан, саналыг авч баталгаажуулсан. | |
| 4.3.9 | Сайдын тушаалаар баталсан төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга | Үйл ажиллагаан ы зардлаар | Байгуулсан гэрээний тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Нийт 130 төсөл хөтөлбөрийн Зөвлөх үйлчилгээний гэрээ | 1/ Сайдын тушаалаар баталсан төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад туссан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээний бэлтгэл хангалт"-ын хүрээнд ТХААГ-аас тендер сонгон шалгаруулалтад шалгарсан этгээдтэй Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулна. | | | | байгуулагдсан байна. | арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад туссан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээний бэлтгэл хангалт /улсын хэмжээнд/”-ын хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтын дагуу ТХААГ-аас тендер сонгон шалгаруулалтад шалгарсан этгээдтэй Зөвлөх үйлчилгээний гэрээг тухай бүр байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. 2/ Хуулийн хэлтсийн зүгээс Сайдын 2023 оны А/51 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулах 131 төсөл, арга хэмжээ"-ний 69 гүйцэтгэгчтэй холбогдох гэрээг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хариуцан байгуулсан байна. | |
| 4.4. | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргана. | - | - | - | - | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2022 оны хэрэгжилт, Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилт, Яамны эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэхээр туссан Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2022 оны хэрэгжилт, Шинэ сэргэлтийн бодлогын 2023 оны хэрэгжилтэд Засгийн газрын 2020 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайлан болон холбогдох бусад материалыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус тус тайлант хугацаанд хүргүүлж ажилласан. | |
| 4.4.1 | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2022 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Тайлангийн тоо | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2021 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2022 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. /1 тайлан/ | Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 2022 оны жилийн эцсийн улсын хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01/75 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хүргүүлж, Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 25-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Улмаар “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ний биелэлтийг Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр, Улсын Их Хурлын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлсэн. | |
| 4.4.2 | Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилтэд хяналт- | Үйл ажиллагаан ы зардлаар | Тайлангийн тоо | Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилтэд | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын | Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | | | хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. /1 тайлан/ | Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т тусгасан төсөл, арга хэмжээний 2022 оны жилийн эцсийн улсын хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01/75 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хүргүүлсэн. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 150 төсөлд 2022 онд нийт төсөвт өртгийн 27.5 хувь буюу 13.6 их наяд төгрөгийн санхүүжилт хийхээр төсөвлөж, гүйцэтгэлээр төсөвлөсөн дүнгийн 44.0 хувь буюу ойролцоогоор 6.0 их наяд төгрөгийн санхүүжилт хийсэн байна. Энэ нь нийт төсөвт өртгийн 12.1 хувийг эзэлж байна. Батлагдсан нийт 150 төсөл, арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 45.7 хувийн биелэлттэй гарсан. Энэхүү бодлогын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | баримт бичгийн 2023 оны хэрэгжилтийн тайланг хуулийн хугацаанд гаргах хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яам болон “ЖАЙКА” Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас “Улсын хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн чадавх бэхжүүлэх MDPI-TA төсөл”-тэй хамтран “Улсын хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилтийн тайлан боловсруулах сургалт”-ыг 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, Төсвийн ерөнхийлөн захирагч, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Биеийн тамир спортын улсын хорооны хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагч нарт хийж, УХОХ-ийн ач холбогдол, хяналт-шинжилгээ, хавсралт маягтыг хэрхэн бөглөх, өнгөрсөн жилүүдэд гарсан алдаа дутагдлын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | талаар санал солилцсон. | |
| 4.4.3 | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Тайлангийн тоо | Яамны эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан арга хэмжээний 2022 оны эхний хагас жилийн болон жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эхлэх газар хүргүүлнэ. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: - Яамны эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан арга хэмжээний 2023 оны эхний хагас жилийн болон жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эхлэх газар хүргүүлнэ. | Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд Эдийн засаг, хөгжлийн яамнаас хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг яамны дотоод бүтцийн нэгжүүдээс нэгтгэн авч Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан нийтлэг журмын дагуу үнэлгээ хийж сар бүрийн 10-ний дотор www.unelgee.gov.mn цахим системд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжилтийг тайлагнаж ажилласан. Мөн “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан Эдийн засаг, хөгжлийн яамнаас хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан нийтлэг журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 02/1164 тоот албан бичгээр хүргүүлсэн бол 2023 оны жилийн эцсийн биелэлтэд нийтлэг журамд заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүргүүлэхээр ажиллаж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.4.4 | Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилт, 2023 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Тайлангийн тоо/ тоо/ | Монгол Улсын хөгжлийн 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | Эхний хагас жилд: -Жилийн эцэст: Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2023 оны эхний хагас болон жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна. /2тайлан/ | Улсын Их Хурлын 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 56 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан төсөл, арга хэмжээний жилийн эцсийн биелэлтийг яамд, байгууллагуудаас ирүүлсэн материалд үндэслэн боловсруулж, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, танилцуулга, холбогдох тайлангийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01/74 албан бичгээр хүргүүлсэн. Улмаар “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний биелэлтийг Засгийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газрын 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 05 дугаар тэмдэглэлээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр, Улсын Их Хурлын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлсэн. Улсын Их Хурлын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-ний эхний хагас жилийн хэрэгжилтийг гаргах хүрээнд яамд, Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Монголбанк, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Санхүүгийн зохицуулах хороо, Нийслэлийн Засаг дарга нарт “Хэрэгжилт ирүүлэх тухай” 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 01/965 тоот албан бичгийг хүргүүлсэн. Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд хэрэгжилтийг баталгаажуулж, хэрэгжилт ирүүлсэн яам, аймгуудын тайланг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан нийтлэг журмын хавсралтын дагуу тайланг нэгтгэж, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 02/1164 дугаартай албан бичгээр тайлан, танилцуулга, холбогдох материалыг хүргүүлсэн. | |
| 4.4.5 | Яамны эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэхээр туссан Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний | Үйл ажиллагааны зардлаар | Тайлангийн тоо/тоо/ | Яамны эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэхээр туссан Монгол | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Яамны эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэхээр | Улсын Их Хурлын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | | | Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг ЗГХЭГ-т тайлант хугацаанд хүргүүлсэн. | туссан Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний эхний хагас болон жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цахим системээр тайлагнасан байна./2 тайлан/ | Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-нд Эдийн засаг, хөгжлийн яамны эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэхээр туссан 5 бүлэг 18 зорилго 75 арга хэмжээнээс Эдийн засаг, хөгжлийн яамны үндсэн хариуцагчаар тусгагдсан 3 бүлгийн хүрээнд 3 зорилго, 4 төсөл, арга хэмжээ, 4 шалгуур үзүүлэлт, хамтран хариуцагчаар тусгагдсан 1 зорилго, 1 төсөл, арга хэмжээ, 5 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг журмын дагуу үнэлсэн. Нийт 4 зорилгын хүрээнд 5 төсөл, арга хэмжээ, 9 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. “Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-нд Эдийн засаг, хөгжлийн яамны хариуцан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 5 төсөл, арга хэмжээний хэрэгжилт эхний хагас жилийн байдлаар 90.0 хувьтай үнэлэгдсэн. Засгийн газрын Хяналт-шинжилгээ, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үнэлгээний цахим санд хэрэгжилтийг хуулийн хугацаанд тайлагнаж баталгаажуулсан буюу Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 01/1070 дугаартай албан бичгээр тайлан, танилцуулга, холбогдох материалыг хүргүүлсэн. Жилийн эцсийн хэрэгжилтийг хуулийн хугацаанд буюу 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор тайлагнахаар ажиллаж байна. | |
| 4.4.6 | Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2022 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | Үйл ажиллагаан ы зардлаар | Тайлангийн тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2022 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ./1 тайлан/ | "Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7.7.1-т заасны дагуу Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | чиглэлийн 2022 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан танилцуулгыг 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 01/377 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Аймаг, нийслэлийн таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланг ЗГХЭГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний www.new.unelgee.gov.mn цахим мэдээллийн сангаар баталгаажуулж, хяналтад авч ажилласан. “Аймаг, нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг батлахдаа дийлэнх аймгууд үндсэн 8 зорилгын хүрээнд зорилт, үйл ажиллагааг баталсан бөгөөд Булган, Дархан-Уул аймгууд 7 зорилгын хүрээнд, Өвөрхангай аймаг 4 зорилгын хүрээнд, нийслэл 9 зорилгын хүрээнд арга хэмжээг баталсан байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тайлант онд нийт 724 зорилт 3,101 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийснээс 36.9 хувь нь үр дүнтэй, 36.8 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн, 22.2 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай, 4.1 хувь нь үр дүнгүй үнэлэгдэж, дунджаар 76.5 хувиар үнэлэгдсэн. Аймаг тус бүрээр үнэлгээг гаргахад нийт дүнгээр 17 аймаг тодорхой үр дүнд хүрсэн гэж үнэлэгдсэн бөгөөд Сэлэнгэ аймаг 89.8 хувь, Төв аймаг 88.1 хувийн үнэлгээтэй гарч, 2022 оны хэрэгжилтээр хамгийн өндөр үнэлгээтэй гарсан бол Сүхбаатар аймаг 55.1 хувь, Завхан аймаг 52.8 хувийн биелэлттэй үнэлэгдэж удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байна. Цаашид авч хэрэгжүүлэх арга | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэмжээний тухайд 3 санал боловсруулсан. | |
| 4.4.7 | Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайлан мэдээг боловсруулна. | Үйл ажиллагааны зардлаар | Явцын тайлангийн тоо | Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2022 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.. | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: Баримт бичгийн 2022 оны хэрэгжилтийн явцын мэдээллийг нэгтгэн тайлан мэдээг боловсруулсан байна. | УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 2022 оны хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.2-т заасны дагуу үндсэн 9 зорилго 47 зорилтын хүрээнд зорилтын хүрээнд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 9 зорилгын хэрэгжилт дунджаар 69.03 хувьтай гарсан бөгөөд “зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай” гэж үнэлэгдсэн. Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн сан /www.unelgee.gov.mn/-гаар баталгаажуулан, хяналтад авч нэгтгэсэн бөгөөд 16 яам, 5 агентлаг, нийслэл, 20 аймгаас тайланг хугацаандаа ирүүлсэн. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн чиглэлийн дагуу уг бодлогын 2022 оны хэрэгжилтэд хийсэн явцын тайланг 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 01/1565 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 02 дугаар сарын 29 дүгээр захирамжийн дагуу байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явц, онцлох ажлууд”-ын тайланг 2020-2023 оны 1 дүгээр улирлын байдлаар эцэслэн бэлтгэж, 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулсан “Шинэ сэргэлтийн бодлого” анхан шат-2023 хэлэлцүүлгийн арга хэмжээний үеэр бүх аймаг, сум, багийн 3,000 орчим Засаг дарга нарт танилцуулсан. | |
| 4.4.8 | Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үйл ажиллагаан ы зардлаар | Тайлангийн тоо | Шинэ сэргэлтийн бодлогын 2022 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хүргүүлсэн. | Эхний хагас жилд: -Жилийн эцэст: Шинэ сэргэлтийн бодлогын 2023 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хүргүүлсэн байна./ 1 тайлан/ | Коронавируст халдвар /КОВИД-19/-т цар тахлын эдийн засагт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулж, эдийн засгийн суурийг тэлэх, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, төрийн бүтээмжийг сайжруулах зорилготойгоор Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр, Хөгжлийн төсөл, Монгол Улсын Их Хурлын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлэх болон Монгол Улсын Их Хуралд 2022 онд үе шаттайгаар өргөн мэдүүлж, хэлэлцүүлэх хуулийн төслийн 2023 оны хэрэгжилтийг яамд, байгууллагуудаас ирүүлсэн материалд үндэслэн нэгтгэн боловсруулж, Засгийн газрын 206 дугаар тогтоолын 6.2.2-т заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 1/“Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6 сэргэлтийн бодлогын хүрээнд 29 зорилт, 103 үйл ажиллагааны явц дунджаар 56.2 хувьтай, 2/“Шинэ сэргэлтийн бодлого”-ын 6 сэргэлтийн хүрээнд нийт 94 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөгжлийн төслөөс хэрэгжих хугацаа болоогүй 14 төсөл байгаа бөгөөд хэрэгжиж эхэлсэн 80 төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 44.1 хувьтай, 3/"Шинэ сэргэлтийн бодлого"-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлэх хуулийн төслийн жагсаалтад 7 хуулийн төслийг баталсан бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар 100.0 хувийн хэрэгжилттэй гэж тус тус үнэлэгдсэн. Тус хөгжлийн зорилтот хөтөлбөрийн 2023 оны явцын хэрэгжилтийн тайлан, танилцуулга болон холбогдох бусад материалыг 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 01/1510 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.4.9 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Тайлангийн тоо | Эдийн засаг, хөгжлийн яамны эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2021 оны биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, ЗГХЭГ-т хүргүүлсэн. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Яамны эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2022 оны жилийн эцсийн болон 2023 оны эхний хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. /2 тайлан/ | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3 дахь заалтыг баримтлан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэх аргачлалаар хяналт-шинжилгээ, үнэлгээг сар бүрийн 10-ны өдрийн дотор хийж Засгийн газрын unelgee.gov.mn цахим системд тайлагнан ажилласан. Яамны эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2022 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/111 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2023 оны эхний хагас | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, тайлан танилцуулгыг бэлтгэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 01/1235 дугаартай албан бичгээр хүргүүлж ажилласан. | |
| 4.4.10 | Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Тайлангийн тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Эдийн засаг, хөгжлийн сайдын Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан 2022 оны гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргасан байна. /1 тайлан/ | Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “Яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах нийтлэг ажил эрхэлнэ:”, 7.1.4-т “төсвийн ерөнхийлөн захирагчаас яам, агентлаг, Засгийн газраас байгуулсан бусад байгууллага, холбогдох аймаг, нийслэлийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулах, гэрээний биелэлтийн явц, үр дүнд хяналт тавих, дүгнэх;”, 7.1.6-т “аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын бүтцийн нэгж, Засаг даргын дэргэдэх холбогдох | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;” гэсэн заалт болон Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2022 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 1 жилийн хугацаанд байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 79.1 хувийн биелэлттэй, “зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, цаашид үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай” гэж дүгнэгдсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдөр Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газарт хүргүүлсэн. Улмаар Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газраас гэрээний биелэлтийг 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 01/400 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Мөн 2023 оны гэрээний биелэлтийн явцад эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 72.0 хувьтай үнэлэгдсэн бөгөөд тайланг 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газарт хүргүүлсэн. | |
| 4.4.1 1 | Байгууллагын 2022 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үйл ажиллагаан ы зардлаар | Тайлангийн тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Эдийн засаг, хөгжлийн яамны 2022 оны стратеги | Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны А-46 тушаалаар баталсан яамны 2022-2024 онд хэрэгжүүлэх стратеги | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. /1 тайлан/ | төлөвлөгөөний 2022 оны хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.7-т заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 2022 онд 50 арга хэмжээ 100 хувийн биелэлттэй, 4 арга хэмжээ 90 хувийн биелэлттэй, 7 арга хэмжээ 70 хувийн биелэлттэй, 4 арга хэмжээ 50 хувийн биелэлттэй, 5 арга хэмжээ 30 хувийн үнэлгээтэй, дунджаар 88.6 хувийн биелэлттэй гарсан бөгөөд тайланг 2023 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн 01/181 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | |
| 4.4.12 | Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний | Үйл ажиллагааны зардлаар | Тайлангийн тоо | Эдийн засаг хөгжлийн яамны 2021 | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Эдийн засаг | Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | | | оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, ЗГХЭГ-т хүргүүлсэн. | хөгжлийн яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. /1 тайлан/ | хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 02/301 дугаартай албан бичгээр тайлан танилцуулгыг хавсралтын хамт бэлтгэн боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын “2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд 24 стратеги зорилтын хүрээнд 92 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаснаас жилийн эцсийн байдлаар дунджаар 96.2 хувийн биелэлттэй үнэлэгдсэн. Жилийн эцсийн байдлаар нийт 92 арга хэмжээнээс “үр дүнтэй” буюу 100 хувийн хэрэгжилттэй 79 арга хэмжээ, “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 90 хувийн хэрэгжилттэй 5 арга хэмжээ, ”тодорхой үр дүнд хүрсэн буюу” 70 хувийн хэрэгжилттэй 6 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | арга хэмжээ, “эрчимжүүлэх шаардлагатай буюу 50 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ, “үр дүнгүй” буюу 30 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ байна. Нийт дундаж үнэлгээгээр 96.2 хувийн үнэлгээтэй байна. | |
| 4.4.13 | Байгууллагын 2022 оны ил тод байдлын үнэлгээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Тайлангийн тоо | Байгууллагын 2021 оны ил тод байдлын үнэлгээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ЗГХЭГ-т хүргүүлсэн. | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: Байгууллагын 2022 оны ил тод байдлын үнэлгээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. /1 тайлан/ | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр хавсралтаар батлагдсан “Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг тайлагнах хүснэгт”-ийн дагуу үйл ажиллагааны ил тод байдал, хүний нөөцийн ил тод байдлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 99.4 хувийн биелэлттэй үнэлэгдсэн. Үүнд, үйл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээлэл, хүний нөөц, үзүүлж байгаа үйлчилгээний болон бусад мэдээллийн нээлттэй ил тод байдал 100 хувийн биелэлттэй, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл 98.0 хувийн биелэлттэй байна. Мөн албан хаагчийг сонгон шалгаруулах журмыг байгууллагын цахим хуудас https://med.gov.mn/ хүний нөөцийн ил тод үйл ажиллагаа хэсэгт байршуулж байна. Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсанд сул орон тооны зарыг байршуулан 18 орон тоог нөхөх сонгон шалгаруулалт зарлаж 40 хүн бүртгүүлж 26 хүн шалгалтад орсноос 18 иргэн тэнцсэн бөгөөд Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн тушаалаар төрийн албанд жинхлэн томилсон | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байна. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 12 сарын 7-ны өдрийн А/141 тушаалаар үнэлгээний багийг нэгжийн дарга нарын болон хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, Засгийн газрын мэдээллийн цахим сан болох www.plan.igoverment.mn программд нийт албан хаагчид цахимаар гүйцэтгэлийн тайланг оруулж нэгжийн дарга нар нь үнэлгээг баталгаажуулсан байна. Ил тод байдлын 2022 оны хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, танилцуулга холбогдох материалыг 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 02/301 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.4.14 | Байгууллагын 2023 оны үйл ажиллагааны тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Тайлангийн тоо | Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ЗГХЭГ-т хүргүүлсэн. | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: Байгууллагын 2023 оны үйл ажиллагааны тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. /1 тайлан/ | Эдийн засаг, хөгжлийн яамны 2022 оны жилийн эцсийн үйл ажиллагааг бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын чиг үүргийн болон нээлттэй байдлын үзүүлэлт гэсэн үндсэн 3 үзүүлэлт 8 арга хэмжээний биелэлтийн хүрээнд дүгнэхэд ерөнхий үнэлгээ 89.16 хувь буюу 4.46 оноотой үнэлэгдсэн бөгөөд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.1-т заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн яамны 2022 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлан, танилцуулга холбогдох материалыг 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 02/301 тоот албан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | |
| 4.4.15 | Байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц /Хувь/ | Байгууллагын шилэн дансны хуулийн 2022 оны хэрэгжилтэд хяналт тавьсан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, яамны удирдлагад танилцуулсан байна. /100 хувь/ | Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн дагуу Эдийн засаг, хөгжлийн яамны Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийх удирдамжийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдаар 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдөр батлуулж, шилэн дансны нэгдсэн цахим хуудас www.shilendans.gov.mn-д байршуулсан яамны 2023 оны 1-4 дүгээр сарын мэдээлэл оруулсан байдалд 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 26-ны өдрийг дуусталх хугацаанд дотоод аудит хийсэн. Мэдээллийг төрийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сангийн дансны хуулга, удирдлагын гаргасан хөрөнгө мөнгө зарцуулсан тушаал шийдвэр болон хүний нөөц, худалдан авах ажиллагаатай холбоотой тушаал, шийдвэртэй тулган шалгаж, нягтлан бодогч болон бусад албан хаагчаас нэмэлт тодруулга, мэдээллийг авч ажиллаа. Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь тайлагнасан эсэхийг мэдээллийн төрлөөр авч үзэхэд, 2023 оны 1-4 дүгээр сарын байдлаар төсөв/гүйцэтгэлийн чиглэлээр 6 төрлийн 15 мэдээлэл тайлагнахаас 13 нь хугацаандаа мэдээлэгдсэн, 2 мэдээллийг шилэн дансанд мэдээлээгүй байна. Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт чиглэлээр 5 төрлийн 11 мэдээлэл оруулахаас 13 мэдээллийг хугацаанд нь оруулж, 2 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээллийг мэдээлээгүй, бусад мэдээллийн хувьд төрлийн 20 мэдээлэл оруулахаас 19 мэдээллийг хугацаандаа, 1 мэдээллийг хугацаа хоцроож тайлагнажээ. Нийт 46 мэдээлэл тайлагнахаас 42 мэдээллийг хугацаандаа, 1 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг тайлагнаагүй бөгөөд 2023 оны 1 дүгээр улирлын Шилэн дансны хуулийн хэрэгжилт 91.3 хувьтай үнэлэгдсэн. Цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай 5 чиглэлийн хүрээнд зөвлөмж боловсруулж, цаашлаад дотоод аудитын тайланг яамны удирдлагад 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр танилцуулсан. | |
| 4.4.16 | Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц /Хувь/ | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Байгууллагын санхүүгийн үйл | Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т заасныг үндэслэн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | аудит, хяналт шалгалт хийнэ. | | | | ажиллагаанд дотоод аудит хийж, яамны удирдлагад танилцуулсан байна. /100 хувь/ | 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдаар байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх тухай удирдамжийг батлуулсан. Удирдамжид заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн яамны 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд төлөвлөгөөт дотоод аудитыг 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн ажлын 11 хоногт хийж гүйцэтгэсэн. Дотоод аудитаар 2023 оны эхний хагас жилийн яамны санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль болон холбогдох дүрэм, журам, тушаал, шийдвэрт нийцсэн эсэхэд үнэлэлт өгч, тайлант хугацаанд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, засаж сайжруулах эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох ажилтнуудад танилцуулан дүгнэлт, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвлөмж өгч ажилласан. | |

*Үнэлсэн:* *Ч.Хүрэлбаатар*

*Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд.* *Ч.Хүрэлбаатар* */................................/*

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

*........................*

*(огноо)*

*Тайлагнасан:* *И.Батхүү*

*Төрийн нарийн бичгийн дарга* *И.Батхүү* */................................/*

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

*........................*

*(огноо)*